



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Цогт
Отгонжаргалын БАДАМХАНД

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС ӨРСӨЛДӨӨНИЙГ
ХЯЗГААРЛАХЫГ ХОРИГЛОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Мэргэжлийн индекс
042101

Эрх зүйн бакалаврын
зэрэг горилсон
Дипломын төсөл

Удирдсан
Л. Отгонбаяр /Л.М./

Улаанбаатар. 2024



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ТЭНХИМ

Цогт

Отгонжаргалын БАДАМХАНД

**ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГААС ӨРСӨЛДӨӨНИЙГ
ХЯЗГААРЛАХЫГ ХОРИГЛОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**



Мэргэжлийн индекс
042101

**Эрх Зүйн Бакалаврын Зэрэг
Горилсон Дипломын Төсөл**

Удирдагч: Л. Отгонбаяр /LL.M/

Шүүмжлэгч: Б. Мөнгөннахиа /LL.M/

Улаанбаатар. 2024

ГАРЧГИЙН ТОВЬЁГ

МЭДЭГДЭЛ	i
ТАЛАРХАЛ.....	ii
ТОВЧ ХУРААНГУЙ.....	iii
ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	iv
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	v
ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ	vi
ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	vii
ОРШИЛ	1
Сэдвийн хамрах хүрээ	1
Сэдэв сонгосон үндэслэл.....	1
Судалгааны ажлын зорилго	2
Судалгааны ажлын зорилт	2
Судалгааны ажлын арга зүй.....	2
Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр	3
Сэдвийн судлагдсан байдал	4
I. БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА	6
1.1 Өрсөлдөөний эрх зүйг судлах нийгэм эдийн засгийн ач холбогдол	7
1.1.1 Өрсөлдөөний эрх зүйг судлах нийгэм дэх ач холбогдол.....	8
1.1.2 Өрсөлдөөний эрх зүйг судлах эдийн засгийн ач холбогдол.....	9
1.1.3 Зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоо	10
1.2 Өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн төрлүүд.....	15
1.2.1 МУ-ын өрсөлдөөний тухай хууль.....	19
1.3 Захиргааны байгууллага түүний тухай ойлголт	19
1.3.1 Захиргааны байгууллагын төрөл, ангилал	20
1.3.2 Захиргааны байгууллагын шийдвэр түүний төрлүүд	23

1.3.3	Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах.....	25
II. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ		31
2.1	Захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа өрсөлдөөнийг хязгаарлах шинжтэй эсэхийг тогтоох нь.....	31
2.1.1	Дүн шинжилгээ	31
2.1.2	Кейс анализ (Электрон тамхи борлуулахыг хориглосон засаг даргын захирамжтай холбоотой шүүхийн шийдвэр).....	34
2.2	Захиргааны байгууллагын шийдвэр жижиг дунд бизнес эрхлэгчдийн зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа эсэхийг тогтоох нь.....	37
III. БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА.....		42
3.1	Шударга өрсөлдөөний төлөөх захиргааны байгууллага.....	42
3.2	Төрийн захиргааны байгууллагаас зах зээлийн өрсөлдөөнд оролцох оролцоо.....	44
3.2.1	Татаас буюу дэмжлэг /Subsides/	45
3.2.2	Хариу арга хэмжээний тухай /Countervailing measurements/.....	48
ДҮГНЭЛТ.....		50
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....		51
НОМ ЗҮЙ.....		52
ХАВСРАЛТ.....		54

МЭДЭГДЭЛ

Энэхүү бакалаврын зэрэг горилсон дипломын судалгааны ажил нь миний өөрийн бүтээл мөн болохыг баталж байна. Уг бүтээл нь СЭЗИС-ийн оюуны өмч мөн бөгөөд зөвхөн сургуулийн номын сангаар дамжуулан нийтийн хүртээл болгохыг зөвшөөрч байна.

Нэр: О. Бадамханд

Гарын үсэг:

Огноо: 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд мэргэжлийн зөвлөгөө, удирдлагаар хангаж ажилласан дипломын удирдагч багш Л.Отгонбаяр (LL.M, Edinburgh) болон тэнхимийн багш Б.Мөнгөннахиа (LL.M) нарт талархсанаа илэрхийлж байна. Мөн суралцах хугацаанд үргэлж дэмжиж, тусалж байсан гэр бүл, найз нөхөд, ажлын хамт олонд талархал илэрхийлье.

ТОВЧ ХУРААНГУЙ

Зах зээлийн шударга өрсөлдөөн нь бизнес эрхлэгчдэд өсөн дэвжих боломжийг олгодог бол хэрэглэгчдэд сонголт хийх давуу талыг бий болгодог ач холбогдолтой. Таны худалдан авалт хийж буй аливаа бүтээгдэхүүн бүрийн ард өрсөлдөөний эрх зүйн хууль тогтоомжоор зохицуулагдсан харилцаа явагдаж байдаг. Манай улсын хувьд өрсөлдөөний эрх зүйн харилцааг зохицуулагч гол хууль нь 2010 онд батлагдсан “Өрсөлдөөний тухай” хууль юм. Уг хуулиар өрсөлдөөнд харшлах олон төрлийн үйл ажиллагаануудыг нарийвчлан зааж өгсөн байдаг. Тэдгээрээс “Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох” харилцааг онцгойлон энэхүү судалгааны ажлаар судалсан болно. Өөрөөр хэлбэл зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд төрийн захиргааны байгууллагаас оролцох нь онол болон практикийн хувьд ямар үр нөлөө үзүүлдэг талаар судалж эдийн засгийн харилцаан дахь эрх зүйн суурь яагаад чухал болох ач холбогдлыг тодорхойлсон болно.

Түлхүүр үгс: *Нийтийн эрх зүй, Шударга өрсөлдөөн, Захиргааны байгууллага, Үнэ тариф, Өрсөлдөөнийг хязгаарлах, Татаас буюу дэмжлэг*

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Судлагдсан байдлын судалгаа.....	4
Хүснэгт 1.2 Захиргааны байгууллагын төрөл.....	21
Хүснэгт 2.1 Дүн шинжилгээ.....	32
Хүснэгт 2.2 Тандалт судалгаа.....	39

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1 Өрсөлдөөний эрх зүйн ач холбогдол ба уялдаа холбоо	6
Зураг 1.2 Зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоо.....	11
Зураг 1.3 Захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох төрлүүд.....	19
Зураг 1.4 Гүйцэтгэх эрх мэдлийн ангилал	20
Зураг 1.5 Нийтийн эрх зүйн хэлбэр	23
Зураг 1.6 Аж ахуйн нэгжийн тоо.....	27
Зураг 1.7 Аж ахуй нэгж, байгууллагын тоон мэдээлэл.....	28
Зураг 1.8 Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, харьцуулалт	29
Зураг 2.1 ААН-үүдийн үйл ажиллагаа явуулж буй байршил.....	38
Зураг 3.1 Татаасын төрөл.....	46

ХАВСРАЛТЫН ЖАГСААЛТ

Хавсралт 1. Тандалт судалгааны асуулга.....54

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

Нэршил товчлол	Тайлбар
ААН	Аж ахуй нэгж
ААЭ	Аж ахуй эрхлэгч
ДХБ	Дэлхийн худалдааны байгууллага
ШӨХТГ	Шударга Өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөөх газар

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Нэршил товчлол	Тайлабр
Административ	Засгийн газар болон бусад захиргааны байгууллагын захиргааны шинжтэй үйл ажиллагааг ойлгоно
Губернатив	Засгийн газрын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг ойлгоно
Картель	Өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ хэлцлийг зах зээлийн хөндлөн түвшинд хийхийг ойлгоно
Татаас	Засгийн газраас үйлдвэрлэгчид болон ААН-үүдэд өгч буй татаас, тусламж дэмжлэгийг ойлгоно
Хариу арга хэмжээ	Засгийн газраас татаас ашиглах үед гардаг сөрөг үр дагавруудын эсрэг авч буй хариу арга хэмжээнүүдийг ойлгоно

ОРШИЛ

Сэдвийн хамрах хүрээ

Чөлөөт эдийн засгийн зарчимтай манай улсын хувьд зах зээлийн шударга өрсөлдөөн улс орны хөгжил дэвшилтэй шууд хамааралтай. Өрсөлдөөний эрх зүй нь нийтийн болон хувийн эрх зүйн аль, аль талын шинжийг агуулдаг онцлогтой (Т. Мөнх-Эрдэнэ, n.d.). Өрсөлдөөний эрх зүй нь хувийн эрх зүйн салбар болохын хувьд тэгш эрхтэй субъектүүдийн хооронд байгуулагдсан гэрээний үндсэн дээр үүсдэг. Харин нийтийн эрх зүй болохын хувьд төр түүний гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагуудын захирамжилсан шийдвэрийн дагуу зохицуулагдаж харилцаа бий болдог(Т. Мөнх-Эрдэнэ, n.d.). Монгол улс Үндсэн хуулиараа төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч субъектүүдийг тодорхойлсон. Үүнд:

- Хууль тогтоох эрх мэдлийг Улсын их хуралд;
- Шүүх эрх мэдлийг Шүүх байгууллагад;
- Гүйцэтгэх эрх мэдлийг засгийн газарт;

Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагууд өөрийн эрх хэмжээний асуудлаар шийдвэр гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд ажиллан эдийн засагт харшилсан бус, өрсөлдөөнийг үл хязгаарласан шийдвэр гаргах ёстой. Захиргааны байгууллага үйл ажиллагаагаа явуулахдаа хүний эрх, эрх чөлөөнд халдсан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг нийгмийн харилцаанд болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан агуулга бүхий шийдвэр гаргах нь хориотой байдаг. Гэвч зарим тохиолдолд захиргааны байгууллага өөрийн аливаа үйлдэл, эс үйлдэхүйгээрээ өрсөлдөөнийг хязгаарлах тохиолдол Монгол улсад цөөнгүй гардаг. Иймд уг судалгааны ажлаараа өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийг нийтийн эрх зүйн хүрээнд буюу төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр гаргадаг эсэх, түүнийг хэрхэн хориглодог талаарх эрх зүйн зохицуулалтыг онцлон судалсан болно.

Сэдэв сонгосон үндэслэл

Зах зээлийн шударга өрсөлдөөн нь эдийн засгийн өндөр ач холбогдолтойгоос гадна нийгэмд буюу хэрэглэгчдэд сонголт хийх давуу талыг бий болгодог. Зах зээлийн

өрсөлдөөний үр дүнг хэрэглэгчид шууд мэдэрдэг учраас энэ төрлийн харилцааг судлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Өөрөөр хэлбэл таны яг одоо худалдан авалт хийх бүтээгдэхүүний үнэ, чанар, сонголт зэрэг нь өрсөлдөөний эрх зүйн харилцаатай шууд холбоо хамааралтай. Ийнхүү шударга өрсөлдөөний зарчим нь хөгжиж буй орны хувьд өсөн дэвжих экосистем байтал төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах шийдвэр гаргадаг эсэх, энэ нь ямар үр нөлөөтэй байдаг талаар уг судалгааны ажлаар судалсан болно.

Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгааны ажлаар нийтийн эрх зүйн салбарын үндсэн субъект болох захиргааны байгууллагын өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн өнөөгийн байдлыг судлах болно. Ийнхүү судлахдаа захиргааны байгууллага өөрийн хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулахдаа өрсөлдөөний тухай хууль, зах зээлийн чөлөөт зарчим, шударга өрсөлдөөний зарчим зэрэгт нийцүүлэн ажиллаж байгаа эсэхийг судлан үнэлэлт өгөхийг зорилоо.

Судалгааны ажлын зорилт

Дээрх судалгааны ажлын зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн онолын судалгааг хийх
- Өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн төрлүүдэд харьцуулалт хийх
- Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах аргуудад үнэлэлт хийх
- Өрсөлдөөнийг хязгаарлах агуулга бүхий захиргааны актад нөлөөллийн шинжилгээ хийх
- Төрийн хяналт шалгалттай холбоотой шүүхийн шийдвэрт кейс анализ хийх
- Захиргааны байгууллагаас ААН-үүдийн өрсөлдөөнийг хязгаарлахтай холбоотой судалгаа боловсруулан дүгнэлт хийх

Судалгааны ажлын арга зүй

Энэхүү судалгааг шинжлэх ухааны диалетик арга /Үзэгдэл юмсын бодит байдлыг илрүүлэхэд үүсэл, хөгжил, хөдөлгөөн, шалтгаант холбоо, харилцан хамаарал, эсрэг

тэсрэг шинж, нэгдэл тэмцэл зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан мөн чанар, зүй тогтол, онцлогийг гаргахад чиглэдэг/ Анализын арга болон харьцуулалтын аргыг голчлон ашигласан бөгөөд ингэхдээ логик дэс дараалалд оруулан процессын хувьд судалсан болно. Мөн судалгаандаа судалгааны дедуктив аргыг илүүтэйгээр ашигласан болно. Уг арга нь онол, таамаглал, судалгаа, баталгаа гэсэн үндсэн дарааллаар судалгааг хийдэг. Онолын судалгааг нэгдүгээр бүлгийн хүрээнд хийж түүнээсээ улбаалан захиргааны байгууллага зах зээлийн шударга өрсөлдөөнийг хязгаарладаг уу? гэх таамаглалыг дэвшүүлэн хоёрдугаар бүлгийнхээ хүрээнд,

- Дүн шинжилгээ
- Кейс анализ
- Асуулгын аргыг ашигласан түүвэр судалгааг тус тус хийж дүгнэлтийг боловсруулсан болно.

Шинжлэх ухаан, практикт оруулах хувь нэмэр

Монгол улсад өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн эрх зүйн зохицуулалтын талаар судалсан хэд хэдэн судлаачдын судалгаа байдаг хэдий ч нарийвчлан Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах зохицуулалтыг нийтийн эрх зүйн хувьд авч судалсан судалгаа хараахан байхгүй бөгөөд энэхүү судалгаа нь анхдагч болно. Иймд хууль зүйн шинжлэх ухаанд энэ төрлийн судалгааг оруулж ирснээр бусад судлаачид сонирхон судлах, асуудлыг тодорхойлох, шийдлийг нарийвчлан зохицуулах зэрэг ач холбогдолтой байна. Мөн бид хөгжиж буй орны хувьд эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлэхийн тулд зайлшгүй зах зээлийн шударга өрсөлдөөнийг бүрдүүлэх шаардлагатай юм. Харин бидний өдөр тутмын амьдралд зах зээлийн шударга өрсөлдөөнийг захиргааны байгууллагаас үнэхээр хангаж чадаж байгаа эсэх, хязгаарлалт тогтоодог эсэх зэргийг судалснаар практик хэрэгжилтийн үр нөлөөг дүгнэж цаашдын эрх зүйн орчноо тодорхойлох боломж бүрдэх ач холбогдолтой юм.

Сэдвийн судлагдсан байдал

Монгол улсад Өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн эрх зүйн зохицуулалттай холбоотой дараах судалгааны ажлууд хийгдсэн байна.

Хүснэгт 1.1 Судлагдсан байдлын судалгаа

Судлаачийн нэр	Огноо	Судалгааны ажлын сэдэв	Судалгааны агуулга
С. Цогтгэрэл	2010, Муис	Шударга бус өрсөлдөөн, түүний эрх зүйн зохицуулалт	Зах зээлийн шударга бус өрсөлдөөн, түүний учир шалтгаан эрх зүйн зохицуулалт
Т. Мөнх-Эрдэнэ	2016, LL.M	Өрсөлдөөний эрх зүй: Хувийн ба нийтийн эрх зүйн зэрэгцэл /өгүүлэл/	Өрсөлдөөний эрх зүйг хувийн болон нийтийн эрх зүйн үүднээс тодорхойлсон
Б. Итгэлбат	2016, МУИС-Магистрын зэрэг горилсон судалгааны ажил	Монополийн төрийн зохицуулалт харьцуулсан судалгаа	Монопол өрсөлдөөний эрх зүйн хүрээг тодорхойлон нарийвчилж судалсан ба төрөөс монополийг зохицуулах аргуудыг тодорхойлсон.
ЖАЙКА, ШӨХТГ-ын судлаачид	2017	“Монгол дах шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх нь” техникийн хамтын ажиллагааны төсөл, тайлан, гарын авлага	Өрсөлдөөний төрлүүдийг олон улсын ойлголтоор тайлбарлаж шударга бус өрсөлдөөний шинж чанар, үр дагаврыг тодорхойлсон
Б. Амарсанаа профессороор ахлуулсан зөвлөх баг ба ШӨХТГ	2022 өрсөлдөөний хуулийн онолын сурах бичиг	Өрсөлдөөний эрх зүй: Онол ба практик	Уг ном нь нийт 8 бүлгээс бүрдсэн онолын ойлголт ба практикийг агуулсан.
Б. Батбаяр	2021, СЭЗИС-Бакалаврын	Аж ахуй эрхлэгчдийн босоо чиглэлтэй хэлцлийг өрсөлдөөний	Өрсөлдөөний эрх зүй дэх босоо төрлийн гэрээ

	зэрэг горилсон диплом	эрх зүйн үүднээс судлах нь	хэлцлийг нарийвчлан судалсан
Д. Мөнхтөр	2022, СЭЗИС бакалаврын зэрэг горилсон судалгааны ажил	ШӨХТГ-ын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь	Өрсөлдөөний эрх зүйн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч ШӨХТГ-ын үйл ажиллагаа дахь процессын болон практик хэрэглээнд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлсон
Т. Оюунболор	2023, СЭЗИС-Бакалаврын зэрэг горилсон судалгааны ажил	Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф тогтоолтын өрсөлдөөний эрх зүйн зохицуулалт	Үнэ тариф тогтоолтын эрх зүйн орчны судалгаанд суурилан шударга өрсөлдөөний ач холбогдлыг тайлбарласан

Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Судлагдсан байдлын дүгнэлт:

Дээрх судалгаануудыг тус бүрд нь авч үзэхэд өрсөлдөөний эрх зүйг салбар эрх зүйн хувьд нийтийн болон хувийн эрх зүйн аль нэгт хамаатуулан үзсэн байна. Судлаачдын ихэнх нь В2В гэрээ хэлцлийн картелийн шинж чанар, монополын зохицуулалт, үнэ тариф тогтоох нөхцөл, өрсөлдөөнд харшлах үйлдлүүдийг тусгайлан салган авч үзэж судалжээ. Ингэхдээ онолын үүднээс, олон улстай харьцуулах арга замаар бодлогын түвшинд дүн шинжилгээ, анализ, харьцуулалтын аргуудыг түлхүү ашиглан цаашдын хөгжлийн арга замыг тодорхойлсон байна. Харин нийтийн эрх зүйн хүрээнд төрөөс буюу захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийг нарийвчлан судалсан судалгааны ажил байхгүй байгаа нь энэ төрлийн судалгааны ажил зайлшгүй шаардлагатайг илүү бататгаж байна.

I. БҮЛЭГ. ОНОЛЫН СУДАЛГАА

Энэхүү бүлэгт өрсөлдөөний эрх зүйг судлах нь яагаад чухал болох талаар тайлбарлах бөгөөд өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн төрлүүдийг нарийвчлан авч үзэж, төрөөс буюу захиргааны байгууллагаас зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд хэрхэн оролцдог болон түүний нөлөөллийг онолын үүднээс судлан тайлбарлах болно.

Зураг 1.1 Өрсөлдөөний эрх зүйн ач холбогдол ба уялдаа холбоо



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Дээрх зургаар зах зээлийн өрсөлдөөн бидний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдгийг харуулахыг зорисон болно. Захиргааны байгууллагаас зах зээлд шударга өрсөлдөөнийг ханган ажиллах нь хэрэглэгч болоод бизнес эрхлэгч талуудад аль алинд нь давуу талыг бий болгодог. Шударга өрсөлдөөн нь хэрэглэгчдэд сонголт хийх боломжийг олгодог бол бизнес эрхлэгчдэд бараа бүтээгдэхүүнээ сайжруулах, илүү инновацилаг болох зэргээр өсөлт хийх боломжийг олгодог. Ингэснээр хэрэглэгч, бизнес эрхлэгч нарын эрхгэх холбоо сайжирч улмаар эдийн засагт оруулах хувь нэмэр нь ихэсдэг байна. Өрсөлдөөн нь зах зээлийн эдийн засгийн тулгуур ойлголт бөгөөд тэр дундаа шударга өрсөлдөөн нь эдийн засгийг эрүүлжүүлж, хөгжил дэвшилд хүргэдэг бол шударга бус өрсөлдөөн нь хоцрогдол ядуурал сүйрэлд хүргэдэг(Г. Банзрагч, 2013). Иймээс захиргааны байгууллагаас шударга өрсөлдөөнийг хангахын тулд хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулдаг. Өөрөөр хэлбэл өрсөлдөөний эрх зүй нь захиргааны эрх зүйд хамаарах хамгийн анхдагч үндэслэл нь зах зээл дээрх аливаа өрсөлдөгч нар өрсөлдөөнд

харш хэлцэл хийсэн, үйл ажиллагаа явуулсан гэдгийг шалган тогтоох, хариуцлага оногдуулах чиг үүрэг нь нийтийн захиргааны байгууллага болох Шударга өрсөлдөөн, хэрэглэгчдийн төлөө газар (МУ-ын хувьд)-т байдаг явдал юм(Т. Мөнх-Эрдэнэ, n.d.).

1.1 Өрсөлдөөний эрх зүйг судлах нийгэм эдийн засгийн ач холбогдол

Цаг үеийн тасралтгүй урсгалд эдийн засгийн хурдацтай хөгжлийг дэмжихийн тулд бид бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлагуудтай тулгарч байна. Хөгжиж буй орны хувьд бусад өндөр хөгжилтэй болон хөгжингүй улс орнуудтай харьцуулахад нийгэм, эдийн засгийн олон асуудлууд бидний амьдралд цаг мөч бүр бий болдог. Тэдгээр асуудлуудад олон хүн шүүмжлэлт байр сууринаас ханддаг боловч стратегийн менежментийн хувьд үйлчлүүлэгчийн аливаа асуудлыг шийдвэрлэсэн бизнес тогтвортой, урт удаан оршин тогтнодог хэмээн үздэг. Иймд бизнес хөгжих таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх нь үр дүндээ иргэдийн аливаа төрлийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх мөн улс орны эдийн засгийн өсөлтийг бий болгох үндэс суурь юм.

Тэгвэл “хэрхэн бизнес хөгжих таатай эрх зүйн орчныг бий болгох вэ?” гэсэн асуулт бий болно. Манай улсын хувьд 1990 оноос хойш Ардчилсан нийгэмд шилжин чөлөөт эдийн засгийн бодлоготой болсон. Ингэснээр хувиараа бизнес эрхлэгчид ихсэж иргэд буюу худалдан авагчид сонголт хийх боломж нэмэгдсэн юм. Чөлөөт эдийн засагтай орны хувьд зайлшгүй зохицуулах шаардлагатай чухал асуудлуудын нэг бол эдийн засаг дахь төрийн оролцоо. Төр ААН-үүдийн бизнесийн харилцаанд хэт оролцох, огт оролцохгүй байх нь тус тусдаа эдийн засгийн эерэг болон сөрөг үр дагаврыг бий болгодог.

Уг асуудалд эдийн засгийн болон эрх зүйн судалгаатай үнэлэлт, дүгнэлт хийж төрийн оролцоог хуулиар тогтоож өгөх нь бизнес эрхлэгчдийн хувьд өсөж хөгжих бат бөх, эрүүл үндэс суурь болж буйтай ижил юм. Төр бизнес эрхлэгчдийг шударга өрсөлдөх боломжоор хангасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь хэрэглэгчдэд сонголт хийх давуу талыг бий болгодог. Тэд өөрсдийнхөө бараа бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулахын тулд, нөөц боломжоо илүү ихээр ашиглах, илүү инновацилаг болох, үйлдвэрлэлдээ шинэ техник технологи ашиглах гэх мэтээр борлуулалтаа нэмэгдүүлэх бүх төрлийн хүчин зүтгэлийг гаргана.

Харин дээрх харилцаанд төр захиргааны байгууллагаараа дамжуулан хараа хяналтаа нэмэгдүүлэх, хориглох, хязгаарлах арга хэмжээг хэтрүүлэн авах нь

өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн төрөл болох ба үр дүндээ эдийн засгийн хөгжил удааширна. Иймд уг судалгааны ажлаараа захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийг онцлон судаллаа.

1.1.1 Өрсөлдөөний эрх зүйг судлах нийгэм дэх ач холбогдол

Зах зээлийн шударга бус өрсөлдөөн нь зөвхөн ААН-үүд хоорондын ашиг сонирхлыг хөндөх тухай асуудал биш юм. Дээр дурдсанчлан шударга өрсөлдөөн нь бизнес эрхлэгчдийн хувьд хөгжиж дэвших хамгийн таатай нөхцөл. Уг нөхцөл байдал захиргааны байгууллагаас хэт хараат эсхүл аль нэг монополь, олигополь ААН-үүдээс хамааралтай болчихвол хэрэглэгчдэд сонголт хийх боломж багасах нөхцөл бий болох юм. Энэ төрлийн эрсдэлээс сэргийлэхийн тулд зайлшгүй захиргааны байгууллагын хяналт шалгалт, шаардлагатай. Улс орны хувьд стратегийн чухал ач холбогдолтой түүхий эд, иргэдийн хувьд өдөр тутмын хэрэгцээгээ хангадаг өргөн хэрэглээний хүнс, бараа материалууд мөн түүнчлэн таны өдөр тутамдаа худалдан авалт хийдэг бүтээгдэхүүнүүд ч зах зээлийн өрсөлдөөнтэй холбоотойгоор үнэ чанар нь өөр, өөр байдаг ба сонголт бүрийн тань ард өрсөлдөөний эрх зүйн тогтолцоо шууд нөлөөлдөг.

Зах зээл дэх өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн аливаа хууль бус үйл ажиллагаа нь үр дагаврын хувьд ихэвчлэн нийтийн ашиг сонирхолд үлэмж хохирол учруулдаг ба зах зээлийн эдийн засгийн бүтцэд аюултай нөхцөл байдал үүсгэхээс гадна үнэ тогтох процесс, үнийн зохицуулалтад шууд нөлөө үзүүлдэг. Хөндлөн төрлийн өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлүүд нь эдийн засаг болон нийгэмд олон сөрөг үр дагаврыг авчирдаг. Жишээлбэл өрсөлдөөний эрх зүйн салбарын хамгийн түгээмэл хууль бус үйлдэл болох картелийн талаар авч үзэцгээе. Манай улсын Өрсөлдөөний тухай хууль (2010)-р картелийг тодорхойлохдоо дараах үйлдлүүдийг хамруулан ойлгоно гэжээ. Үүнд:

- Бараа бүтээгдэхүүний үнийг хэлцэн тогтоох
- Зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах
- Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт, борлуулалт, ачилт болон тээвэрлэлт, зах зээлд нэвтрэн орох боломж, хөрөнгө оруулалт, техник, технологийн шинэчлэлийг хязгаарлах
- Уралдаант шалгаруулалт, дуудлага худалдаа болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа,

түүний нэг багц, хэсэгт харилцан хамаарал бүхий этгээдтэй хамт оролцох, эсхүл бусад оролцогчтой өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэл байгуулах, эсхүл үнэ, бусад нөхцөл, шалгуурыг урьдчилан тохиролцох үйлдлүүд нь МУ-д хуулиар хориглогдсон байдаг.

Өрсөлдөгчдийн хоорондын гэрээ нь B2B (business-to-business) буюу аж ахуй эрхлэгчдийн хоорондын гэрээнд тооцогдох боловч зах зээлд дээрх хориглосон үйлдлүүдээс хийхээр тохиролцож байгаа тохиолдолд үр дагавар нь B2B төдийгүй B2C (business-to-consumer) буюу хэрэглэгчийн гэрээний хэлцлийн зардлыг өсгөх, үнэ тариф нэмэх, сонголтыг хязгаарлах, технологийн хөгжлийг хясан хязгаарлах, хомсдол үүсгэх зэрэг сөрөг нөлөөтэй (Л. Отгонбаяр, 2023). Дээрх хөндлөн төрлийн гэрээ хэлцлийн сөрөг үр дагавар нийгэмд шууд нөлөөлдөг. Тиймээс энэ төрлийн эрх зүйн зохицуулалт зайлшгүй байж захиргааны байгууллагаас шударга өрсөлдөөний хяналт шалгалтыг хийх нь нийгэмд өндөр ач холбогдолтой. Өрсөлдөөн нь хэрэглэгчдийн эрх ашиг, худалдах авах чадвар, эдийн засагт шууд нөлөө үзүүлдэг учраас нийгэмд энэ харилцааг төрөөс зохицуулах, төрийн зохицуулалтыг ард иргэд хянадаг байх шаардлагатай.

1.1.2 Өрсөлдөөний эрх зүйг судлах эдийн засгийн ач холбогдол

Өрсөлдөөн нь бизнес эрхлэгчдийн зах зээлд оршин тогтнох, хөгжин дэвшихийн төлөөх тэмцэл ба тухайн бизнес эрхлэгчийг үргэлж хөгжүүлж, дараагийн түвшинд хүргэдэг учраас хэрэглэгчдийн хувьд сонголтыг бий болгодог давуу талтай(Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ, n.d.). Зөвхөн хямд үнээр бус чанар, үйлчилгээ, стандарт зэргээр өрсөлдөх нь улс орны эдийн засаг хурдтай хөгжих үйл явцад өндөр ач холбогдолтой. Өөрөөр хэлбэл шударга өрсөлдөөн нь эдийн засгийн хөгжлийг цэцэглүүлэгч бат бөх үндэс суурь юм. Улмаар бид шударга өрсөлдөөнийг зохицуулах улс орны бодлогыг оновчтой тодорхойлж, төрийн оролцоог хязгаарлагдмал түвшинд хуулиар тогтоож өгснөөр эдийн засаг чөлөөт зарчмын хувьд хөгжих боломж бүрдэнэ. Эдийн засаг дахь төрийн оролцоог судлаачид онолын хувьд дараах байдалтай ангилсан байна(Гочоогийн Банзрагч, 2016). Үүнд:

- Эдийн засаг дахь төрийн оролцоог шүтсэн (маркетализм)
- Эдийн засаг дахь төрийн оролцоог үгүйсгэсэн (либерализм)
- Төрийн зохицуулалтыг тодорхой хүрээнд хүлээн зөвшөөрсөн (интервионизм)

Төрөөс эдийн засгийн харилцааг зохицуулах гол зорилго нь хязгаарлагдмал нийгмийн нөөц баялгийг дээд зэргээр үр ашигтайгаар ашиглах, баялгийг хамгийн боломжит

хэмжээгээр бүтээх, үр өгөөжгүй зардлыг багасгахад орших бөгөөд ингэхдээ нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийтийн баялгийн зохистой хуваарилалтыг хэрэгжүүлэх, шударга бус өрсөлдөөнийг зохицуулж зах зээлийг, өмчийн болон аж ахуй эрхлэх эрхийг баталгаажуулах зайлшгүй шаардлагатай болдог(Гочоогийн Банзрагч, 2016).

1.1.3 Зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоо

Эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий энэхүү өрсөлдөөний эрх зүйд төр хэрхэн оролцох боломжтой байдаг тухай энэхүү хэсгээр авч үзэх болно. Манай улсад 2010 онд батлагдсан “Өрсөлдөөний тухай хууль” хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хууль нь батлагдсан цагаас хойш өнөөдрийг хүртэл нийт арван удаагийн нэмэлт өөрчлөлт орсон. Энэхүү хуулиар бид аж ахуй эрхлэгчийн зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлд ноёлох болон өрсөлдөөнд харш аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, хориглон хязгаарлах, өрсөлдөөнийг зохицуулах байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулдаг байна. Аливаа улс орны өрсөлдөөний хууль нь дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй нэгэнтэйгээ өрсөлдөхгүй байх эсвэл өрсөлдөөнд нь саад учруулах бизнесийг хязгаарласан үйлдлийг арилгах, багасгахыг зорьдог.

Манай улсын хувьд хамгийн анх 1993 онд “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль” УИХ-р хэлэлцэгдэн нийт 5 бүлэг 14 зүйлтэйгээр тус оны 7 дугаар сарын 05-ны өдөр батлагдаж байсан түүхтэй. Үүнээс хойш 7 жилийн дараа буюу 2000 онд тус хууль шинэчлэгдэн найруулагдсан. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 1993 онд батлагдсан хуулийн хэрэгжилтэд тулгамдаад байсан хуулийг хэрэгжүүлэх тогтолцоог хэт задалж олон байгууллагуудын дунд бүрхэгдүүлсэн, аж ахуй нэгжүүдийн нэгдэх, нийлэх, өөрчлөн байгуулах болон зүй ёсны монополь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавих хяналтын талаарх заалтууд практикт хэрэгжихгүй байгаа зэрэг асуудлаас үүдэн хуулийн шинэчилсэн найруулгыг өргөн барьж буй талаар танилцуулгад тодотгож төслийн хүрээнд олон улсын практикт хэрэглэдэг ерөнхий жишигт нийцүүлэн Монгол улс дахь зах зээлийг аль болох шударга үр ашигтай болгохоор зорьжээ(Л. Отгонбаяр, эмхэтгэсэн, 2023).


Ийнхүү шинэчлэгдэн найруулагдсан тус хуульд 2002, 2005, 2008 онуудад тус тус цаг үеийн байдал, бусад хууль тогтоомжийн өөрчлөлт зэрэгтэй холбоотойгоор тус тус нэмэлт өөрчлөлт оруулж байсан байна. Манай улсын өрсөлдөөний тухай хууль ийнхүү

түүхийн хувьд өөрчлөгдөж явсаар одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Өрсөлдөөний тухай хууль нь 2010 онд шинээр батлагдсан байна.

Өөрөөр хэлбэл 2002 оны Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн хэрэгжилтээс ажиглагдсан холбогдох хуулийн үйлчлэх хүрээг тэлэх, Давамгайл байдалтай аж ахуй нэгжийг тодорхойлох зохицуулалтын дутагдалтай байдал, Давамгайл байдалтай аж ахуй нэгж өрсөлдөгч аж ахуй нэгжтэй нэгдэн нийлэхийг шууд хориглосон болон Картел буюу өрсөлдөөнд харш гэрээ, хэлцэл байгуулах үйл ажиллагааны зохицуулалтыг илүү боловсронгуй болгох зэрэг практикт шаардлагын хүрээнд хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар холбогдох онуудад ажилласан (Л. Отгонбаяр, эмхэтгэсэн, 2023) байна. Ийнхүү явсаар бидний өнөөгийн хууль 2010 оны 06 дугаар сарын 10-ны өдөр нийт таван бүлэг, 28 зүйлтэйгээр батлагдаж байжээ.

Зарим тохиолдолд Өрсөлдөөний тухай хуулиар зарим нэг өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцэл, үйл ажиллагааны тодорхой нийгмийн бүлэгт үзүүлэх үр ашиг нь үзүүлж буй сөрөг нөлөөнөөс илүү байгаа бол үүнийг хүлээн зөвшөөрдөг(Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ, n.d.) хэмээн олон улсад үздэг аж. Ийнхүү зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоог судлаачийн зүгээс гурав ангилан авч үзэх боломжтой.

Зураг 1.2 Зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоо



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Чөлөөт зах зээлийн өрсөлдөөн дэх төрийн оролцоог дээрх байдлаар ангилах авч үзэх боломжтой ба манай улсын хувьд төр хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд

өрсөлдөөнд оролцох зохицуулалттай. Дээрх гурван төрлийг тус тус дэлгэрүүлэн тайлбарлавал:

Төр өрсөлдөөнд давамгайлсан оролцох

Төрөөс зах зээлийн үйл ажиллагаануудад хяналт тавихгүй байх нь зарим тохиолдолд шударга бус байдлыг болгодог. Энэ үйл явдал нь ихэвчлэн монополь болон картелийн харилцаанд ажиглагддаг байна. ААН-үүд өрсөлдөөнийг урвуулан ашиглаж өөртөө ашигтай байдлыг бий болгох үед төрөөс хязгаарлалтыг хууль ёсны хүрээнд хийх хэрэгцээ шаардлага байдаг. Үүнийг Эдийн засгийн суурь онолыг үндэслэгч Кейнсийн онолын хүрээнд тайлбарлах нь зохимжтой. Тэрээр зарим зах зээлийг төгс бус өрсөлдөөнтэй байдаг гэж үздэг бөгөөд ийнхүү харьцангуй байх үед нь төр оролцож зохицуулалт хийх ёстой гэсэн байр суурьтай(Паркин, n.d.).

МУ-д төрийн захиргааны байгууллагаас буюу захиргааны байгууллагаас зах зээлийн өрсөлдөөнд хяналт тавьж ажиллан өрсөлдөөнийг урвуулан ашиглах үйлдэлд хууль эрх зүйн хүрээнд хязгаарлалтыг хийж өгдөг. Аливаа төрлийн шударга бус өрсөлдөөн нь тухайн орны эдийн засаг, зах зээлд шууд нөлөө үзүүлдэг талаар дээр дурдсан. Монополь ба олигополь нь нөөцийг үр ашигтай хуваарилахад саад учруулдаг. Эдийн засгийн хурдтай хөгжилд бизнес бүр ашгаа хамгийн их байлгахыг зорьдог бөгөөд монополь болон олигополь зах зээл дээр ажиллаж буй үйлдвэрлэгчид үйлдвэрлэлээ хязгаарлаж, үнээ өндөр байлгах замаар ашгаа өсгөхийг оролддог.


Мөн картель болон өрсөлдөөний элдэв хязгаарлалтыг хориглосон шударга бус өрсөлдөөний хуулийг баталдаг(Паркин, n.d.). Гэвч төрийн хяналт шалгалт хэтрэх үйлдэл нь эргээд ААН-үүдийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлөх боломжтой. Манай улсад зарим тохиолдолд тухайн ААН-ийн үйл ажиллагааны төрлөөс шалтгаалсан захиргааны байгууллагууд өрсөлдөөнд харш үйлдэл хийх тохиолдол байдаг. Жишээлбэл банк санхүүгийн салбарт Засгийн газар, /Монгол/ Төв банк, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг төрийн захиргааны байгууллагууд хяналт шалгалт хийж заавар зөвлөмжийг өгч ажилладаг. Гэвч зарим тохиолдолд эдгээр захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа явуулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр гаргах боломжтой.

Захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа иргэн хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж байгаа үед бид Захиргааны дагнасан шүүхээр тус асуудлыг

шийдвэрлүүлдэг. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны байгууллага эрх хэмжээгээ хэтрүүлэн ашиглах тохиолдолд иргэн хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах шүүх нь Захиргааны хэргийн шүүх юм. Шүүхийн практикт МУ-д анх энэ төрлийн хэрэг маргааныг нарийвчлан шийддэг дагнасан шүүх байгаагүй боловч 2004 оноос эхлэн дагнасан захиргааны шүүхтэй болсон. Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр хэлэлцэгддэг ШӨХТГ-ын улсын байцаагчийн хяналт шалгалтын шийдвэртэй холбоотой нэхэмжлэл гаргах тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Эдгээр тохиолдлууд нь дийлэнхдээ захиргааны сөрөг үйлчлэл /хориглосон, хязгаарласан, эрхийг хассан, үүрэг болгосон/ бүхий акттай холбоотойгоор гардаг. Иймээс бид төрийн захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарладаг эсэхийг шалгахын тулд илүү нарийвчлан судлах шаардлагатай. Ийнхүү судлахдаа дараах ажлуудыг судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Сангийн сайдын чиглэлд дүн шинжилгээ;
- Засаг даргын захирамжтай холбоотой шүүхийн шийдвэрт кейс анализ;
- Бүс нутаг хамарсан тандалт судалгаа;

Зураг 1.2 Нийслэл дэх захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо



Эх сурвалж: Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан (shuukh.mn)

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн өрсөлдөөний хяналт шалгалттай холбоотой улсын байцаагчийн торгууль, шийдвэрийг эс зөвшөөрөн шүүхэд нэхэмжлэл гаргасан сүүлийн 4 жилийн мэдээллийг авч үзвэл

дараах байдалтай харагдаж байна. Эдгээр нь дийлэнхдээ сөрөг үйлчлэл бүхий захиргааны акттай холбоотой.

Төр өрсөлдөөнд огт оролцохгүй байх

Зах зээлийн чөлөөт эдийн засагтай манай орны хувьд өрсөлдөөнд төр давамгайлан оролцох нь эдийн засгийн хөгжлийг гацаах хамгийн том шалтгаан болох боломжтой. Өөрөөр хэлбэл төрийн захиргааны байгууллага ААН-үүдийн шударга өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр гаргах нь тухайн бизнес эрхлэгчид цаашлаад тухайн бизнесийн салбарт, хэрэглэгчдэд хүртэл сөрөг нөлөөтэй. Эдийн засгийн онолын хувьд авч үзвэл шударга өрсөлдөөнөөс хамгийн их үр ашгийг хэрэглэгчид хүртдэг. Учир нь өрсөлдөөн сонголтыг бий болгодог. Адам Смитийн сонгодог эдийн засгийн онол нь зах зээлийн чөлөөт өрсөлдөөн, чөлөөт үнийн механизмд төр засгийн зүгээс ямар нэгэн хязгаарлалт хийхгүй байх ёстой гэж үздэг. Хэрэв ингэж чадвал эдийн засаг жам ёсоороо, үл үзэгдэгч гарын онолын дагуу өөрөө өөрийгөө хөгжүүлэн зохицуулах механизмд ордог гэжээ.

Гэвч практикт төр огт оролцохгүй байх боломж тун бага юм. Өмнө нь дурдсанчлан ААН-үүдийн хооронд өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явагдаж байгаа эсэх хяналт шалгалтыг төрөөс зайлшгүй хийх шаардлагатай. Мөн захиргааны байгууллага болох төр нь тухайн улс орны хэмжээнд хамгийн том худалдан авагч болдог бөгөөд тендер буюу төрийн худалдах, худалдан авах ажиллагааны хүрээнд өрсөлдөөнд оролцдог. Жишээлбэл төр өөрийн дотоодын зах зээл дээрх бүтээгдэхүүнүүдийг худалдан авснаар тухайн салбарт мөнгөн хөрөнгө оруулах хөгжил дэвшилд нь шууд нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

Дээрх боломжит хоёр сонголт болох өрсөлдөөнд төр огт оролцохгүй байх болон давамгайлан оролцох боломжуудад туйлын зөв гэж байхгүй. Учир нь огт төрийн захиргааны байгууллагын оролцоо, хараа хяналтгүй байх ААН-үүд өөр хоорондоо хэлэлцэн тохиролцож зах зээлийг урвуулан ашиглах, ноёрхол тогтоох, үнийг хэлэлцэн тохиролцох, зах зээлийг бүс нутгаар нь хувааж авах зэргээр шударга бус өрсөлдөөний үйлдлүүдийг гаргаж эхэлнэ. Тиймээс уг харилцаанд зайлшгүй захиргааны байгууллага хяналт тогтоож ажиллах шаардлагатай. Харин ийнхүү хяналт шалгалт хийх эрх хэмжээний асуудал нь хуулиас давсан шинжтэй байх тохиолдолд чөлөөт эдийн засгийн

зарчим алдагдана. Иймд уг харилцааг тэнцвэртэй авч явах, хяналт шалгалт хийж буй захиргааны байгууллага хууль ёсны ажиллах зэрэг шаардлагууд үүсээд байна.

Төр өрсөлдөөнд хуулийн хүрээнд оролцох

Манай улсын төрийн захиргааны байгууллагын оролцоо нь энэ төрөлд тохирно. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүйд буюу захиргааны байгууллагуудад хуулиар зөвшөөрөгдөөгүй бүхэн хориглогдох эрх зүйн зарчим үйлчилдэг. Захиргааны байгууллагууд үйл ажиллагаа явуулж шийдвэр гаргахдаа хуульд зааснаас бусдаар давуулан эрх хэмжээгээ хэтрүүлж болохгүй. Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт зааснаар аливаа төрлийн захиргааны хэм хэмжээний актыг гаргахдаа урьдчилан нөлөөллийн шинжилгээг хийхээр зохицуулсан байдаг.

➤ Нөлөөллийн шинжилгээ гэж юу вэ?

Захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргахад олон нийтийн оролцоог хангах, эерэг болон сөрөг талуудыг харьцуулан судалж, шийдвэрийн эдийн засаг, нийгмийн амьдралд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тооцсоны үндсэн дээр тухайн харилцааг зохицуулах үр дүнтэй зохицуулалт бүхий зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, үндэслэл бүхий шийдвэр гаргах нөхцөлийг тодорхойлох зорилготойгоор актыг гаргахдаа өмнө түүнд хийдэг хууль зүйн шинжилгээ юм. Уг шинжилгээгээр тухайн захиргааны байгууллагын гаргах хэм хэмжээний акт хууль бус эсэх, эдийн засаг мөн өрсөлдөөнд харш эсэх, нийгэмд хор хохиролтой зэрэг нь тогтоогддог.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4.4 дэх хэсэгт зааснаар тус шинжилгээг хийснээр хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн харилцаанд болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэхийг шалгах ач холбогдолтой гэжээ.

1.2 Өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн төрлүүд

Өрсөлдөөнийг хязгаарласан гэрээ хэлцлийг өргөн утгаар нь хэвтээ болон босоо хэлбэрийн гэрээ хэлцэл хэмээн ангилдаг. Хэвтээ гэрээ хэлцэл гэж нэг зах зээлд ижил төрлийн бараа ажил үйлчилгээ худалдан борлуулдаг өрсөлдөгч нарыг мөн өрсөлдөх гэж буй ААН хоорондын гэрээ хэлцлийг ойлгоно. Олон улсад уг төрлийн гэрээг В2В буюу

бизнесээс бизнесийн хооронд байгуулах гэрээ гэж үздэг. Босоо гэрээ хэлцэл гэдэгт үйлдвэрлэл, борлуулалтын өөр өөр шатанд үйл ажиллагаа явуулдаг ААН хоорондын хэлцлийг ойлгож болно. Мөн үйлдэгдэж байгаа хэлбэрээс нь шалтгаалан (per se) илт хууль бус болон учир шалтгааны зарчимт (rule of reason) хэмээн ангилдаг байна (Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ, n.d.).

Аж ахуйн нэгж өөрсдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зах зээлийн давамгайл байдлаа зүй бусаар ашиглах, картель хийх зэргээр зах зээлийн жам ёсны өрсөлдөөнийг хязгаарлах, гажуудуулах явдал цөөнгүй байдаг. Өрсөлдөөний хуулиар зах зээлийн шударга бөгөөд чөлөөт өрсөлдөөнийг баталгаажуулж, өрсөлдөөний соёлыг төлөвшүүлж, улмаар улс орны эдийн засгийн эрүүл хөгжлийг хамгаалж байдаг(Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ, n.d.). Өрсөлдөөнийг хязгаарлах гэрээ хэлэлцээр бүхий үйлдэл хийх субъектүүдийг дараах байдлаар ангилах боломжтой.

- Давамгайлагч байдалтай ААН босоо төрлийн өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ хэлэлцээр байгуулах.
- Нэг зах зээлд ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулж буй ААН-үүд өөр хоорондоо харилцан тохиролцож гэрээ хэлэлцээр байгуулах буюу хөндлөн түвшинд картель үйлдэх.
- Аливаа төрлийн Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

НҮБ-ын Худалдаа хөгжлийн бага хурал болон МУ-ын ШӨХТГ нар 2014 онд Өрсөлдөөний хууль ба бодлого /хэрэгжүүлэгчдэд зориулсан/ гэсэн номыг эрхлэн гаргасан. Тус номд хэвтээ болон босоо хэлбэрийн гэрээ хэлцлийг олон улсад онолын үүднээс дараах байдлаар ангилдаг хэмээн тусгасан байдаг.

Өрсөлдөөнийг хязгаарлах хэвтээ хэлбэрийн гэрээ хэлцлүүд

- Тендерт хуйвалдаж оролцох

Энэ төрлийн өрсөлдөөнийг хязгаарлах үйлдэл хамгийн түгээмэл тохиолддог. Тендерт оролцогчид үгсэн хуйвалдаж тохиролцсоны дагуу үнийн саналыг тохиролцох, ээлжилж тендерт ялалт байгуулах зэрэг нь шударга өрсөлдөөнд харш үр дагавартай (ЖАЙКА, 2017) .

- Үнэ тогтоох

Аж ахуй эрхлэгчид харилцан тохиролцох үнэ тарифыг тогтоох нь өрсөлдөөнийг бууруулж, шинэ бөгөөд илүү сайн бүтээгдэхүүн үйлдвэрлэх сонирхолгүй болгодог.(ЖАЙКА, 2017)

- Бүтээгдэхүүний квот

Аж ахуй эрхлэгчдийн худалдан борлуулах бүтээгдэхүүнд квот тогтоох нь тэдний ашиг сонирхолд шууд нөлөөлдөг. Зах зээлийн зарим том үйлдвэрлэгчид өөрт хуваарилагдсан хэмжээнээсээ илүү бүтээгдэхүүн худалдан борлуулж ашиг олох сонирхолтой байдаг. Иймд энэ төрлийн картелийн шинж чанартай гэрээ хэлэлцээрүүд өрсөлдөөнд харш үр дагавартай.(ЖАЙКА, 2017)

- Зах зээлээ хуваах

Зах зээлийг бүс нутгаар нь хуваах худалдан борлуулахыг хязгаарлах нь хэрэглэгчдийн сонголт хийх хүрээг багасгадаг. Мөн орон нутагт ноёлох үйл ажиллагаа явуулах компаниуд ихсэж үнэ тариф өсөж, бүтээгдэхүүний сонголт буурах сөрөг үр дагавартай.(ЖАЙКА, 2017)

- Нийлүүлэлт хийхээс, эсвэл худалдан авалт хийхээс хуйвалдан татгалзах

Ийм төрлийн бизнесийг хязгаарласан гэрээ хэлцлийг заримдаа бойкот гэж нэрлэдэг. Оролцогч компаниуд хуйвалдан тодорхой худалдан авагчдад борлуулалт хийхээ зогсоох эсвэл хязгаарлах, мөн эсэргээрээ тодорхой нийлүүлэгчдээс худалдан авахаа зогсоох эсвэл хязгаарладаг.(ЖАЙКА, 2017)

- Зар сурталчилгааны хязгаарлалт

Зар сурталчилгаа нь өрсөлдөөний үр дүнтэй нэгэн арга бөгөөд өөр өөр бараа үйлчилгээний шинж чанар, өөр өөр брэндийн талаар хэрэглэгчдэд сайн мэдээлэл өгөх, шинээр зах зээлд орж ирж байгаа бараа, үйлчилгээний эрэлтийг урамшуулдаг. Гэвч өрсөлдөгчид нийлүүлэгчид бараа, үйлчилгээгээ сурталчлахгүй байх, явуулж буй сурталчилгааныхаа хэмжээ эсвэл хэлбэрийг хязгаарлах тухай тохиролцох тохиолдол гардаг байна.(ЖАЙКА, 2017)

Өрсөлдөөнийг хязгаарлах босоо төрлийн гэрээ хэлцлүүд

- Дахин борлуулах үнийг тогтоох:

Энэ ойлголт нь үйлдвэрлэгчид өөрсдийн бараа бүтээгдэхүүний жижиглэнгийн үнийг тогтоох гэсэн оролдлого юм. Ихэвчлэн дахин борлуулах хамгийн доод үнийг тогтоож өгдөг. (ЖАЙКА, 2017)

- Онцгой нөхцөл бүхий борлуулалт

Энэ төрлийн борлуулалт нь маш түгээмэл худалдааны практик юм. Үйлдвэрлэгчид өөрийн албан ёсны худалдааны байгууллагууд болон жижиглэнгийн худалдаачдад бараа бүтээгдэхүүн борлуулахдаа өрсөлдөгчийн бараа бүтээгдэхүүнээс худалдан авахгүй байх болзол тавьдаг.(ЖАЙКА, 2017)

- Иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах, бүхэлд нь худалдан авахыг албадах

Энэ нь нэг компани эсвэл хэд хэдэн компанийн нэгдэл өөрийн худалдан авагчдад худалдан авахыг хүсээгүй өөр барааг дагалдуулахыг хэлнэ. Үүний хамгийн хүнд хэлбэр болох бүхэлд нь худалдан авахыг албадах тохиолдолд компани өөрийн бүтээгдэхүүний зөвхөн нэг юм уу хоёр бүтээгдэхүүнийг зайлшгүй худалдан авах шаардлагатай байгааг тохиолдуулан өөрийн бүтээгдэхүүнийг бүхэлд нь худалдан авахыг шаардахыг хэлнэ.(ЖАЙКА, 2017)


Дээрх өрсөлдөөнийг хязгаарлах төрлүүд нь Аж ахуй эрхлэгч хоорондын өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлүүд бөгөөд төрийн захиргааны байгууллагаас эдгээр үйл ажиллагаанууд явагдахаас урьдчилан сэргийлэх үүргийг хүлээдэг. Мөн энэ төрлийн үйл ажиллагаа явагдсан эсэхийг хянан шалгах эрх бүхий байгууллага нь манай улсад ШӨХТГ-с гадна салбар хариуцсан захиргааны байгууллагууд байдаг. Тэгвэл энэхүү захиргааны байгууллагууд өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулах боломжтой юу? Эрх мэдэл хуваарилах онолын дагуу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллагууд зарим тохиолдолд үйл ажиллагаа явуулж шийдвэр гаргахдаа эрх хэмжээгээ хэтрүүлсэн, эдийн засаг цаашлаад өрсөлдөөнд харшлах утга агуулга бүхий шийдвэр гаргах боломжтой.(ЖАЙКА, 2017)

1.2.1 МУ-ын өрсөлдөөний тухай хууль.

Дээр дурдсанчлан захиргааны байгууллагууд өрсөлдөөнд харшлах шийдвэр гаргах боломжтой байдаг бол үүнийг манай улсад хэрхэн яаж зохицуулдаг талаар энэхүү хэсэгт авч үзэх болно.

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллагууд эрх хэмжээгээ хэрэгжүүлэн аливаа төрлийн захирамжилсан шийдвэр гаргахдаа өрсөлдөөнд харшлах эсэхийг хянан шалгаж үзэх үүрэгтэй байдаг. /Энэ талаар дараагийн хэсэгт дэлгэрүүлэн тайлбарласан болно/ МУ-ын Өрсөлдөөний тухай хуулиар Төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглосон үйлдлүүдийг дараах байдлаар ангилан авч үздэг.

Зураг 1.3 Захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох төрлүүд



Эх сурвалж: Өрсөлдөөний тухай хууль, 13 дугаар зүйл, 2010

Иймд манай улсын Захиргааны байгууллагууд дээр дурдсан үйл ажиллагааг явуулах хориотой байдаг байна. Энэ төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж чөлөөт өрсөлдөөнд саад учруулах нь тухайн ААН-үүд улмаар хэрэглэгчдэд буюу нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үр дагавартай тул ШӨХТГ мөн энэ төрлийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй.

1.3 Захиргааны байгууллага түүний тухай ойлголт

Төр нь нийгмийг бүхэлд нь зохион байгуулагчийн хувьд нийгэмд нийтлэг хэрэгждэг шийдвэрийг гаргадаг. Ийнхүү шийдвэрт улс орон, нийгэм, эдийн засаг, хөгжлийн гэх мэт нийгмийн олон талт харилцаанд төр субъект болж оролцдог байна.

Захиргааны байгууллага нь төрийн эрх мэдэл хуваарилах сонгодог онолтой шууд хамааралтай бөгөөд уг онолын хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч үндсэн субъект юм. Энэхүү онол нь тэгш байдал ба эрх чөлөөг баталгаажуулах үүднээс төрийн эрх мэдлийг төрийн байгууллагуудад тодорхой зорилгын хүрээнд эрх хэмжээгээр нь хязгаарлан хуваарилахыг ойлгох (Одгэрэл, 2016) ба 1748 онд Францын гүн ухаантан Шарль Луй Монтескьегийн томьёолсон энэхүү онолыг орчин үед дийлэнх ардчилсан улсууд засаглалын үндэс сууриа болгож байна. Түүхийн хөгжлийн явцад олон эрдэмтэд уг онолыг боловсронгуй болгоход гар бие оролцож байсан ба төрийн эрх мэдлийг хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх хэмээн ангилдаг. Монгол улс мөн энэхүү онолыг Үндсэн хуулиараа тогтоосон байна. Үүнд:

- Хууль тогтоох эрх мэдлийг Улсын их хуралд;
- Шүүх эрх мэдлийг Шүүх байгууллагад;
- Гүйцэтгэх эрх мэдлийг засгийн газарт тус тус хуваарилсан байна.

Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч засгийн газар нь төрийн захиргааны байгууллагын дээд удирдлага хэмээн ойлгох боломжтой.

1.3.1 Захиргааны байгууллагын төрөл, ангилал

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллагуудыг ангилсан байдаг. Ийнхүү ангилахдаа онолын хувьд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч захиргааны байгууллагыг дараах байдлаар ангилан авч үздэг.

Зураг 1.4 Гүйцэтгэх эрх мэдлийн ангилал



Эх сурвалж: Судлаачийн эмхэтгэл

Захиргааны байгууллага гэж төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй, нийтийн эрх зүйн хэм хэмжээнд үндэслэгдсэн, тодорхой хариуцсан чиг үүрэгтэй,

түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах тусгай эрх хуулиар олгогдсон, үйл ажиллагаатайгаа холбогдон гарсан хариуцлагыг бие даан хариуцдаг албан хаагчийн солигдохоос үл хамааран байж байдаг ажлын байх юм(П. Одгэрэл, n.d.). МУ-ын захиргааны ерөнхий хуульд тусгагдсанаар захиргааны байгууллагуудыг дараах байдлаар ангилан авч үздэг байна.

Хүснэгт 1.2 Захиргааны байгууллагын төрөл

Захиргааны байгууллага гэж нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдүүд:	
1.	Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага.
2.	Хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус, бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага.
3.	Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үдсэн дээр шилжүүлэн авсан этгээд.
4.	Үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа.
5.	Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага.
6.	Байнгын үйл ажиллагаа явуулдаггүй буюу байнгын бус, нэг удаагийн шинжтэй асуудлыг шийдвэрлэж зохицуулахаар байгуулагдсан захиргааны байгууллага.
7.	Хууль тогтоох шүүх байгууллагууд нь онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг, шийдвэртэй нь холбогдуулан уг байгууллагуудыг захиргааны байгууллагад тооцно.
8.	Нийтийн эрх зүйн асуудлаар бие даан, өөрийн нэрийн өмнөөс дангаар захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар тусгайлан олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллага гэж тооцно.

Эх сурвалж: Захиргааны ерөнхий хууль

Захиргааны байгууллагыг захиргааны чиг үүргийг биелүүлж буй байдлаар нь шууд ба шууд бус хэмээн ангилах боломжтой. Шууд захиргааны байгууллага гэдэгт

засгийн газрын харьяа төрийн гүйцэтгэх байгууллагуудыг ойлгох бол шууд бус захиргааны байгууллагад эрх зүйн хувьд бие даасан хуулийн этгээдүүдийг ойлгоно. Захиргааны байгууллагын төрлийг МУ-ын Захиргааны ерөнхий хуулийн тавдугаар зүйлд ангилсан байдаг. Үүнд:

- Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага
- Хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага
- Захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд
- Үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа
- Нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага
- Байнгын үйл ажиллагаа явуулдаггүй нэг удаагийн шинжтэй үйл ажиллагаанд зориулагдан байгуулагдсан
- Захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар тусгайлан олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллагад тооцно.

Төрийн гүйцэтгэх байгууллагыг эрх хэмжээнийх нь хувьд дараах шинж чанараар хуваан авч үздэг (П. Одгэрэл, n.d.). Үүнд:

- Нийтлэг эрх хэмжээтэй (МУ-ын засгийн газар, бүх шатны засаг дарга)
- Салбарын эрх хэмжээтэй (Санхүүгийн зохицуулах хороо, Эрүүл мэндийн яам, Батлан хамгаалах яам г.м)
- Чиг үүргийн (Үндэсний татварын ерөнхий газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам г.м)

Энэхүү ангилалд багтах захиргааны байгууллагууд захиргааны чиг үүргийг шууд хэрэгжүүлэгч болох бөгөөд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дагнан эрхэлдэг. Аливаа төрлийн захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд үйл


ажиллагаа явуулж шийдвэр гаргахдаа хамгийн түрүүнд хуульд үндэслэх зарчмыг баримтлах үүрэгтэй байдаг.

Гэвч нийгмийн бүх харилцааг нарийвчилсан хуулиар зохицуулах боломжгүй бөгөөд үүнд эдийн засгийн суурь зарчмууд ч багтдаг байна.

1.3.2 Захиргааны байгууллагын шийдвэр түүний төрлүүд

Нийтийн эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй захиргааны байгууллагын илрэн гарах хэлбэр дараах байдалтай байдаг байна.

Зураг 1.5 Нийтийн эрх зүйн хэлбэр



Эх сурвалж: П. Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахтай холбогдсон харилцааны үндсэн захиргааны үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд хэм хэмжээний актаас үүдэлтэй байдаг байна. Тэгвэл захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно (П. Одгэрэл, n.d.). Захиргааны байгууллагаас гарч буй актууд нь агуулгаасаа шалтгаалан эерэг үйлчлэл бүхий захиргааны акт, сөрөг үйлчлэл бүхий захиргааны акт хэмээн ангилдаг. Эдгээрийг дэлгэрүүлэн тайлбарлавал:

- Эерэг үйлчлэл бүхий захиргааны акт

Эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий болгосон захиргааны актыг ойлгоно. Өөрөөр хэлбэл эрх зүйн хувьд ашигтай талыг иргэдэд үүсгэж өгөх эсвэл түүнийг нь баталгаажуулсан шинжтэй акт гаргахыг ойлгож болно. Жишээлбэл газар эзэмших зөвшөөрөл олгох, тодорхой нөхцөлд татвараас чөлөөлөх, хөнгөлөх гэх мэт байж болно. Харин эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт нь өрсөлдөөний эрх зүйн хувьд дэмжих эсхүл хязгаарлах хоёр талын шинжтэй байх боломжтой.(П. Одгэрэл, n.d.)

- Сөрөг үйлчлэл бүхий захиргааны акт

Сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд үүрэг бий болгосон, эсхүл түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хязгаарласан захиргааны актыг ойлгоно. Өөрөөр хэлбэл сөрөг нөлөөлөл нь иргэдийн субъектив эрхэнд халдсан эсвэл түүнд ашиггүй нөхцөл байдал үүсгэж байгаагаар илэрдэг. Жишээлбэл ямар нэгэн үйлдэл хийхийг хориглох, үүрэг болгох, иргэдийн хүсэлтээс татгалзах, бусад ашигтай шийдвэр, хөнгөлөлтийг хүчингүй болгох шийдвэр бүхий захиргааны актыг сөрөг нөлөөлөлтэй гэж ойлгоно.(П. Одгэрэл, n.d.)

Зах зээлийн чөлөөт өрсөлдөөнтэй холбоотойгоор сөрөг нөлөөлөл бүхий актууд нийгэмд гардаг. Жишээлбэл үйл ажиллагаа явуулахыг хориглох, худалдан борлуулахыг зогсоох, хязгаардах төрлийн актууд багтана. Төрийн захирах эрх мэдлийг шууд хэрэгжүүлж буй зарим субъектүүд нь чөлөөт эдийн засаг, зах зээл, өрсөлдөөний тухай гүнзгий ойлголтгүйн улмаас Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчсөн сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гаргах үйлдлүүд гарч байна. Үүний нэгэн жишээ бол 2023 оны тавдугаар сарын тавны өдөр гаргасан Дархан-Уул аймгийн засаг дарга болон Баян өлгий аймгийн засаг даргын орлогчийн гаргасан “Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай” гэсэн агуулга бүхий захирамж юм. Уг захиргааны акт нь эрх зүйн хувьд сөрөг нөлөөлөл бүхий хориглосон шинжтэй бөгөөд өрсөлдөөний тухай хуулийн 13.2.1 буюу төрийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглосон үйлдэл буюу аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан шинжтэй үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэсэнд хамаарч байна.

1.3.3 Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах

Захиргааны байгууллага нийтийн эрх ашигтай холбоотой нийгмийн олон талын эрх зүйн харилцаанд оролцдогийн нэг бол өрсөлдөөний эрх зүй юм. Захирамжилсан үйл ажиллагаа явуулахдаа хориглосон, зөвшөөрсөн, журамласан, тогтоосон, эсхүл татгалзсан үйлдэл эс үйлдэхүйн шийдвэр гаргахыг захиргааны байгууллагаас гарч буй шийдвэр гэж ойлгоно. Захиргааны байгууллагууд нь аливаа нэг тохиолдлыг шийдвэрлэх, эсхүл байнга үйлчлэх шинжтэй хэм хэмжээний актыг гаргах явцдаа эрх зүйн хэм хэмжээг давсан, хууль зөрчсөн захиргааны акт болон хэм хэмжээний актыг үйлдэл болон эс үйлдэхүйгээрээ гаргах боломжтой. Ийнхүү хууль зөрчин гарсан захиргааны актуудыг дараах байдлаар ангилагдана. Үүнд:

- Илт хууль бус захиргааны акт
- Хууль бус захиргааны акт

Мөн эрх зүйн зөрчилгүй ч захиргааны актыг цуцлах үндэслэлүүд байдаг. Жишээлбэл тухайн захиргааны акт нийтийн эрх ашигт үл нийцсэн, шинэ нөхцөл байдал тогтоогдсон зэрэг нөхцөл байдалд хууль зөрчөөгүй захиргааны актыг бүрэн болон хэсэгчлэн хүчингүй болгох боломжтой.

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаа нь салбар бүрээр өөр өөр зохицуулалттай маш том нийтийн эрх зүйн салбар юм. Жишээлбэл аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоох эрхийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиар тогтоосон байдаг. Аймгийн засаг дарга нар уг эрхийнхээ хүрээнд захиргааны сөрөг нөлөөлөл бүхий актыг үйлддэг бөгөөд хязгаарласан, хориглосон нөлөөлөл агуулсан уг акт нь өрсөлдөөний тухай хуулийн 13-р зүйлийг зөрчсөн гэж хэд хэдэн ААН-үүд захиргааны анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж байсан байна. Гэвч хэдийгээр энэхүү акт нь сөрөг нөлөөлөл бүхий боловч нийтийн субъектив эрх ашгийг хөндөөгүй учраас нөлөөлөл нь хэвээр үлдээхээр шүүх шийдвэрээ гаргасан байна.

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр хэлэлцэгддэг ШӨХТГ-ын улсын байцаагчийн хяналт шалгалтын шийдвэртэй холбоотой нэхэмжлэл гаргах тоо жилээс

жилд өсөн нэмэгдэж байна. Эдгээр тохиолдлууд нь дийлэнхдээ захиргааны сөрөг үйлчлэл /хориглосон, хязгаарласан, эрхийг хассан, үүрэг болгосон/ бүхий акттай холбоотойгоор гардаг. Иймээс бид төрийн захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарладаг эсэхийг шалгахын тулд илүү нарийвчлан судлах шаардлагатай. Ийнхүү судлахдаа дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Сангийн сайдын чиглэлд дүн шинжилгээ;
- Засаг даргын захирамжид кейс анализ;
- Бүс нутаг хамарсан тандалт судалгаа;

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах онцгой тохиолдлууд


Өрсөлдөөний эрх зүй нь нийтийн эрх зүйн нэг хэсэг болохын хувьд шударга бус өрсөлдөөн явагдаж байгаа тохиолдлуудад хяналт шалгалт хийж хязгаарлалт тавих эрх хэмжээтэй. Гэвч зарим онцгой тохиолдолд захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарлахыг хуулиар зөвшөөрдөг. Энэ төрлийн тохиолдол хэдий ховор ч зах зээлийн бүлэг, салбараасаа хамаараад өөр өөр байдаг. Жишээлбэл хүнсний үйлдвэрлэлийн салбарыг сонгож авбал энэ төрлийн харилцаанд төрийн хяналт шалгалт, зохицуулалт зайлшгүй хэрэгтэй байдаг.

Мөн согтууруулах ундааны зохицуулалт дээр төрийн захиргааны хараа хяналт оролцоо шаардлагатай. Үүнийг дэлгэрүүлэн авч тайлбарлавал Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтууруулахтай тэмцэх тухай хуулийн 23.1-д Аймаг, нийслэлийн засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоох эрх хэмжээ олгогдсон байдаг. Хэдийгээр уг зүйл заалт өрсөлдөөний тухай хуулийг шууд зөрчсөнд тооцогдохгүй ч тухайн нутаг дэвсгэр бүрд өөр өөр байхаар зохицуулж өгсөн нь зах зээлийг нутаг дэвсгэрийн хүрээгээр хязгаарлах байдлыг бий болгосон гэж үзэх үндэслэлийг бий болгож байгаа юм.

Гэвч зайлшгүй төрийн оролцоо шаардлагатай салбарт шинэчлэлт хийх, захиргааны байгууллагын оролцоогүй болгох нь өөрөө хууль эрх зүйн орчинд олон сөрөг үр дагаврыг авчирдаг. Жишээлбэл хүнсний бүтээгдэхүүн дундаас сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт манай улсад байдаг. Сүү, Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаанд тавигдах нарийн шаардлагууд

байгаа нь хэрэглэгчдийн эрүүл аюулгүй байдлын төлөө хийж буй хамгийн том төрийн захиргааны байгууллагын шалгуур юм. Тухайн салбарын үйлдвэрлэл борлуулалтыг эхлэх, тусгай зөвшөөрөл авахтай холбоотой захиргааны байгууллагаас тавигддаг шаардлагуудыг өрсөлдөөнийг хязгаарлах арга хэрэгсэл мэтээр ойлгох нь энэ салбарт зохимжгүй юм. Тэгвэл манай улсад нийт хэдэн төрлийн, хэчнээн тооны аж ахуй эрхлэгчид байдаг, тэдгээрт захиргааны байгууллагаас хэрхэн яаж оролцдог зэргийг мэдэх шаардлага бий болох юм. Манай улс 5 жил тутамд нийт улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй ААН-үүдийн тоон судалгааг статистик мэдээллийн санд бүртгэдэг. Уг судалгаа хамгийн сүүлд 2021 онд хийгдсэн бөгөөд тухайн үед:

Зураг 1.6 Аж ахуйн нэгжийн тоо




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо 2022 он

Аж ахуйн нэгж, байгууллагын тоо жил бүр өсөн нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд чөлөөт эдийн засгийн тогтолцоотой болох нь хүн бүрд бизнес эрхлэгч байх боломжийг олгодог давуу талтай. 1998 оноос хойш 2021 он хүртэл манай улсын аж ахуй нэгж байгууллагууд 18,950 – 180,006 буюу ойролцоогоор 10 дахин өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Энэхүү ангилалд хувиараа хөдөлмөр эрхлэгч нийт 53,927 бизнес эрхлэгч бүртгэгдсэн байна. Тэгвэл бид эдгээр ААЭ-н зах зээлийн шударга өрсөлдөөнд захиргааны байгууллагын оролцоог тодорхойлох шаардлагатай.

Ийнхүү тоологдсон ААЭ-ийн үүсгэн байгуулагдсан хэлбэрээр нь ангилан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Зураг 1.7 Аж ахуй нэгж, байгууллагын тоон мэдээлэл




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Иймд бидний анхаарч үзэх ёстой ашгийн төлөөх байгууллагуудын эцсийн нийлбэр 205,484 болж байгаа ба эдгээр байгууллагууд үнэхээр зах зээлийн чөлөөт зарчмын дагуу шударгаар өрсөлдөж байгаа юу эсвэл зарим тохиолдолд төрийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээг хэтрүүлэн эдгээр ААН-үүдийн өрсөлдөөнд харшлах утга агуулга бүхий шийдвэр гаргаж байгааг дараагийн бүлгээр тодорхойлсон болно.

Төрийн захиргааны байгууллагаас зах зээлийн өрсөлдөөнд оролцох нь тухайн ААН-ийн үйл ажиллагааны хэлбэр болон салбараас ихээхэн шалтгаалдаг тухай дээр авч үзсэн билээ. Тэгвэл манай улсад ямар төрлийн бизнесийн салбар голчлон үйл ажиллагаагаа явуулж байгаа нь дараах зургаас харагдаж байна. Мөн уг мэдээллийг харьцуулан оруулж аль салбар хамгийн их өсөлттэй байгааг тодорхойлохыг зорьсон болно. Ингэснээр тус салбарт зах зээлийг өрсөлдөөнийг захиргааны байгууллагаас хязгаарлаж байгаа эсэхийг тогтоох, судалгааны салбарыг оновчтой тодорхойлох зэргүүдэд ач холбогдолтой юм. Доорх судалгааны үр дүнд худалдааны салбар хамгийн их хувийг эзлэхээс гадна өсөлттэй байгаа учраас хоёрдугаар бүлгийн тандалт судалгааны хэсгээрээ худалдааны салбарт ажиллаж буй аж ахуй нэгжүүдээс тандалт судалгааг түүвэрлэн авч дүгнэлтийг боловсруулсан болно.

Зураг 1.8 Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, харьцуулалт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Дээрх судалгааны үр дүнгээс харахад манай улсад үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид аж үйлдвэр болон худалдааны салбарт илүүтэйгээр нэмэгдэн үйл ажиллагаагаа явуулж байгааг харж болохоор байна. Худалдааны салбарт том жижиг бүхий л бизнесүүдийг хамруулан ойлгох боломжтой бөгөөд ихэнх жижиг бизнес эрхлэгчдийн хувьд захиргааны байгууллагын хяналт шалгалт багатай байдаг нь энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэх үндсэн шалтгаануудын нэг болж байна. Жишээлбэл:

- Томоохон худалдааны төвүүдэд бараа бүтээгдэхүүн борлуулдаг лангуу ажиллуулж түрээс төлдөг бизнес эрхлэгчдийн хувьд төрийн хяналт шалгалт бусад салбартай харьцуулахад маш бага. Харин зах зээлд томоохон байр суурь эрхэлдэг үйлчилгээг нь олноороо хэрэглэдэг стратегийн шинжтэй салбарт төрийн оролцоо их байдгийг буруутгах аргагүй. Төрийн захиргааны оролцоо хяналт шалгалт бүрийг өрсөлдөөнийг хязгаарласан шинжтэй гэж үзэх нь өөрөө өрөөсгөл ойлголт юм.

Иймд төрийн захиргааны байгууллагын ямар үйлдэл өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа, ямар үйлдлийг төрөөс хэтрүүлэн хийж байгаа зэргийг судлах шаардлага үүсээд байна.

Бүлгийн дүгнэлт

Онолын хэсгийнхээ хүрээнд судалгааны ажлын үндсэн судлагдахуунуудыг онол, практикийн хувьд тайлбарласан болно. Ингэхдээ захиргааны байгууллага түүний үйл ажиллагаа болон шийдвэрийн талаар, өрсөлдөөний эрх зүйн орчин болон хуулиар хориглосон үйл ажиллагаа зэргийг дэлгэрүүлэн тайлбарласан. Аливаа төр зах зээлийн өрсөлдөөнд давамгайлан оролцох, огт оролцохгүй байх, хуулийн хүрээнд оролцох төрлүүдийг онолын хувьд тайлбарласан болно. Манай улсын хууль эрх зүйн орчны хувьд төр хуулийн хүрээнд өрсөлдөөнд оролцохоор тогтоосон байдаг.

Гэвч зарим тохиолдолд төрийн захиргааны байгууллагууд өөрсдийн эрх хэмжээг хэтрүүлсэн үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах зэргээр хуулиар тогтоосноос давсан захиргааны үйл ажиллагаа явуулдаг байна. Зах зээлийн шударга өрсөлдөөн нь ААН-с гадна хэрэглэгчдэд сонголт хийх давуу талыг олгодгоороо онцлогтой. Иймд зах зээлийн чөлөөт өрсөлдөөнд төрийн захиргааны байгууллага үнэхээр өөрийн эрх хэмжээг хэтрүүлсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг дараагийн бүлгээрээ судалсан болно.

II. БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Энэхүү бүлгээр өмнөх бүлэгт судалсан захиргааны байгууллагууд өрсөлдөөнд харшлах үйл ажиллагаа явуулж шийдвэр гаргадаг эсэхийг тодорхойлохын тулд хэд хэдэн төрлийн судалгааны арга ашиглан үр дүнг боловсруулсан болно.

2.1 Захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа өрсөлдөөнийг хязгаарлах шинжтэй эсэхийг тогтоох нь

Судалгааны үндсэн хэсэг болох Монгол улсад Төрийн захиргааны байгууллагаас зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарладаг эсэхийг хянан шалгахын тулд үндсэн гурван төрлийн судалгаа ашиглаж үр дүнгээ боловсруулсан болно. Ингэхдээ онолын хэсгээр судлагдсан мэдээлэлд тулгуурлан хоёр төрлийн захиргааны байгууллагын шийдвэрт дүн шинжилгээ болон кейс анализ хийсэн.

2.1.1 Дүн шинжилгээ

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарласан үйлдлийн хамрах хүрээ, давтамж, нөлөөлөл, эрх зүйн зохицуулалтыг судлахын тулд 2014 онд тухайн үеийн сангийн сайдыг ШӨХТГ-с торгож байсан шийдвэр буюу Сангийн сайдын чиглэлийг судаллаа. Манай улсад захиргааны байгууллагаас гарч буй шийдвэрт гарсных нь дараа үр нөлөөг нь судлан дүн шинжилгээ хийх тусгайлсан арга байдаггүй ба зөвхөн тус шийдвэрийг гаргахын өмнө хийдэг нөлөөллийн шинжилгээ л байдаг. Иймд тус шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ нөлөөллийн шинжилгээний аргачлалыг ашиглан хийсэн болно.

/Ийнхүү дүн шинжилгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/147 дугаар тушаалын хавсралтын дагуу нөлөөллийн шинжилгээний загварыг ашиглан хийж гүйцэтгэв./

Шийдвэрийн тухайд:

Сангийн сайд асан 2014 онд Төрийн банкны төгрөгийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд бүх төрийн өмчит их дээд сургуулийг санхүүгийн үйлчилгээгээ зөвхөн Төрийн банкаар дамжуулан хийх тухай чиглэл гаргасан. Захиргааны байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд Сангийн сайдын уг чиглэл өрсөлдөөнийг хязгаарласан эсэхийг дараах байдлаар шалган тогтоов.

Хүснэгт 2.1 Дун шинжилгээ

№	Чиглэл	Шалгах	Нөлөөлөл
1	Уг чиглэлийг гаргах	Үндэслэл	Төрийн банкны эх үүсвэр багассан
		Шаардлага	Төрийн банкны эх үүсвэрийг нэмэгдүүлэх
		Зорилт	Төрийн банкны төгрөгийн нөөцийн санг нэмэх
2	Тухайн чиглэлийн	Ерөнхий бүтэц	Сангийн сайдын чиглэл албан бичиг хэлбэртэй
		Зохицуулах харилцаа	Төрийн өмчит их дээд сургуулиудын санхүүгийн үйлчилгээ
		Хамрах хүрээ	Төрийн өмчит их дээд сургуулиудын удирдлага
3	Чиглэл нь гарсны дараа	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлэг	МУ-д тухайн үед үйл ажиллагаа эрхэлж байсан нийт банкнуудын
4	<u>Тухайн чиглэлийн төсөл нь</u>	Хүний эрх, эрх чөлөөнд халдсан эсэх	Үндсэн хуульд заасан жам ёсны эрхэнд халдаагүй.
		Өрсөлдөөнийг хязгаарласан эсэх	Өрсөлдөөний тухай хуулийн 13.2.7 Аль нэг ААЭ-д давуу байдал олгоход чиглэсэн үйл ажиллагааг захиргааны байгууллага явуулахыг хориглосон байтал уг чиглэл дээрх заалтыг зөрчсөн.
		Эдийн засаг, нийгмийн бусад үйл ажиллагаанд саад учруулсан эсэх	Бусад банкны өрсөлдөх чадварыг бууруулсан шийдвэр гаргасан
		Хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн эсэх	-
5	Тухайн чиглэл нь	Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-

6	Тухайн чиглэл нь	Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай ААН хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Төрийн өмчит их дээд сургуулиудын төлбөрийг Төрийн банканд л төвлөрүүлэх нь бусад гадны хөрөнгө оруулалттай банкнуудыг ялгаварласан үйлдэл.
7	Тухайн чиглэл нь	Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болох эсэх	-
8	Тухайн чиглэл нь	Зах зээлд шинээр нэвтэрч буй ААН-д хүндрэл үүсэх эсэх	Шинээр зах зээлд гарч ирж буй Банк нь төрийн өмчит их дээд сургуулийн санхүүгийн үйлчилгээг хүлээн авахгүй нөхцөл байдал үүснэ.
9	Тухайн чиглэл нь	Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Төрийн өмчийн их дээд сургуулиуд зөвхөн Төрийн банкаар санхүүгийн үйлчилгээгээ хийх нь хэрэглэгчдийн буюу оюутнуудын хувьд сонголт хийх эрх чөлөөг хаасан, өөрийн хэрэглэдэг банкнаас Төрийн банк-руу төлбөр хийхэд гарах үйлчилгээний хөлсөөр хохироосон шийдвэр болсон.
10	Тухайн чиглэл нь	ААН-ийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	-

Дээрх сангийн яамны сайдын чиглэлд нөлөөллийн шинжилгээний загварыг ашиглан дүн шинжилгээ хийхэд холбогдох хэсгүүд болох 4 дүгээр хэсэг болох Өрсөлдөөнийг хязгаарласан эсэх, Эдийн засаг, нийгмийн бусад үйл ажиллагаанд саад учруулсан эсэх, Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалттай ААН хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлсэн эсэх, Зах зээлд шинээр нэвтэрч буй ААН-д хүндрэл учруулсан эсэх, Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх үзүүлэлтүүдээр **өрсөлдөөнд харш үр дагавартай** гарч байна.

Энэ нь Өрсөлдөөний тухай хуулийн 13-р зүйл болох Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага хуульд зааснаас бусад тохиолдолд хориглосон үйл ажиллагаа буюу 13.2.7-д заасан аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход чиглэсэн үйлдэл болж байна. Тиймээс уг шийдвэрт ШӨХТГ-с хяналт шалгалт хийсний үр дүнд “Төрийн банк”-нд давуу эрх олгох үйлдэл хийсэн хэмээн үзэж Захиргааны ерөнхий хуулийн 86.1-т заасан захиргааны шийдвэр гүйцэтгэлийн албадлагын төрлийн 86.1.1-т заасан торгууль оногдуулах арга хэмжээг авсан нь хууль зүйн үндэслэлтэй байна.

2.1.2 Кейс анализ (Электрон тамхи борлуулахыг хориглосон засаг даргын захирамжтай холбоотой шүүхийн шийдвэр)

/Уг кейс анализыг хийхдээ Н. Баярмаа LL.M, Өрсөлдөөний эрх зүй ба гэрээ судалгааны ажилд ашигласан ерөнхий загвараар хийсэн болно./

Маргаан бүхий захирамжийн тухайд:

Дархан-Уул аймгийн засаг дарга өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд захирамж гаргахдаа тухайн бүс нутагт аливаа төрлийн Электрон тамхи(вейп), түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглосон захирамж гаргасан байна. Уг захирамж нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийг зөрчиж өрсөлдөөнийг хязгаарласан эсэхийг дараах байдлаар шалгасан болно.

Нэхэмжлэгч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ:

2023 оны 5 дугаар сарын 5-ны өдөр гаргасан засаг даргын захирамж нь Монгол улсын үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 3, Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсныг соёрхон батлах хуулт, Тамхины хяналтын суурь конвенцийн 1 дүгээр зүйлийн (е), 4 дүгээр зүйлийн 4, 5 дугаар зүйлийн 2.б, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 11 дүгээр зүйлийн 11.1.2, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн иргэд, өсвөр үе, залуучуудыг тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор тухайн аймгийн нутаг дэвсгэрт электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг 2023 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хориглож шийдвэрлэсэн байна гэжээ. Мөн тэрээр

шүүх хуралд гаргасан тайлбартаа манай компани нь электрон болон ахуйн бараа, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жижиглэнгийн худалдааны үйл ажиллагаа эрхлэн явуулдаг бөгөөд түүний нэг хэсэг нь электрон тамхи худалдаалах үйл ажиллагаа юм гэжээ. Нэхэмжлэгч компани нь компанийн дүрмийн 4.2-т заасан үйл ажиллагааны хүрээнд Монгол улсад хоёр төрлийн брэндийн электрон тамхи, түүнийг дагалдах хэрэгслийг импортлон оруулж ирэн харилцагч дэлгүүртэй гэрээ байгуулан худалдаалах үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. Эдгээр харилцагч нарт Дархан-Уул аймаг дахь худалдааны дэлгүүрүүд багтдаг. Монгол улсын Үндсэн хуулийн арван зургаадугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын иргэн хувийн аж ахуй эрхлэх үндсэн эрхийг баталгаатай эдэлнэ, Мөн Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “компани нь хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа эрхэлж болох бөгөөд компани нь үйл ажиллагаагаа эрхлэхэд шаардагдах эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэж заасны дагуу нэхэмжлэгч компани нь хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагаа явуулах эрхтэй гэж заасан байдаг.

Хэдий тийм боловч манай компанийн зүгээс электрон тамхийг 21 нас хүрээгүй этгээдэд худалдаалахгүй гэдэг бизнесийн ёс зүй, нийгмийн хариуцлагаа бүрэн ухамсарласны үндсэн дээр үйл ажиллагаагаа эрхэлдэг. Тухайлбал өнгөрсөн хугацаанд хариуцагч нарын биеийн байцаалтыг шалгасны үндсэн дээр худалдах шаардлага тавих, тамхины хор хөнөөлийг сурталчлан таниулах хэвлэмэл хуудас, самбар, дүрс бичлэг бэлтгэн нийтлэх, ерөнхий боловсролын сургуулиудаас 500 метр дотор цахилгаан тамхин бүтээгдэхүүн худалдахгүй байх, тус шаардлагыг дэмжихгүй харилцагч нартай гэрээгээ цуцлах зэрэг үйл ажиллагааг бодитоор төсөв зарцуулж явуулж ирсэн гэжээ (*Шүүхийн шийдвэр*, 2023).

Шүүхийн шийдвэрийн нэр:

2023 оны 7 дугаар сарын 7-ны Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны 14/ШШ2023/0015 дугаар бүхий шүүхийн шийдвэр - [МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ \(supremecourt.mn\)](http://supremecourt.mn)

Үйл явдлын Факт:

Нэхэмжлэгч 2023 оны 5 дугаар сарын 5-ны өдөр Засаг даргын гаргасан “Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай” захирамжийг

эс зөвшөөрч шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Тус захирамж нь Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хэн ч электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулах үйл ажиллагаа явуулж болохгүй гэсэн агуулгатай байсан нь байна. Нэхэмжлэгч нэхэмжлэлдээ засаг дарга өөрийн эрх хэмжээ, чиг үүргээ хэтрүүлэн өрсөлдөөнийг хязгаарласан утгатай захирамж гаргасан гэж маргажээ. Мөн нэхэмжлэгч хуулиар хориглоогүй үйл ажиллагааг хориглосноор Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хуулиар хориглоогүй бараа бүтээгдэхүүнээ худалдах нэхэмжлэгчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг шууд зөрчиж байна гэж үзжээ.

Шүүхийн шийдвэрлэсэн байдал:

Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлага болох Засаг даргын захирамжийг бүхэлд нь хүчингүй болгох шаардлагыг бүхэлд ханган шийдвэрлэсэн. Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-т “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр, гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг” ойлгохоор заасан. Мөн тус зүйлийн 37.7-д зааснаар нийтлэг шинжээр тодорхойлогддог, эсхүл тодорхойлж болохуйц этгээдэд чиглэсэн эсхүл эд юмсын нийтийн эрх зүйн байдлыг тодорхойлох, түүнийг ашиглахтай холбоотой захиргааны акт байж болно.

Гэвч маргаан бүхий засаг даргын захирамж нь “Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг 2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс хориглосон” агуулгатай тул нэг удаагийн тохиолдлыг зохицуулаагүйгээс гадна нийтлэг шинжээр тодорхойлогдох боломжгүй, тодорхойгүй тооны этгээдүүдийн тодорхой тооны үйлдэлд чиглэсэн тул захиргааны актад хамаарахгүй юм хэмээн шүүхээс үзжээ.

Өөрөөр хэлбэл электрон тамхи нь Тамхины хяналтын тухай хуулийн үйлчлэлд хамаардаггүй тул электрон тамхийг худалдаалахад аливаа тусгай болон энгийн зөвшөөрөл авах шаардлагагүй байдаг байна.

Судлаачийн дүгнэлт:

Засаг даргын тус захирамж нь өрсөлдөөний тухай хуультай харшилдаж байгаа ба тус хуулийн 13.2.1-т заасан аж ахуй эрхлэгчийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах,

бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан шийдвэр юм. Засаг дарга хэдийгээр шүүхэд гаргасан тайлбартаа өөрийн эрх хэмжээний бүс нутагт зохистой хэрэглээг түгээх зорилготой гаргасан гэсэн боловч энэ нь захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийн нэгэн жишээ болж байгаа ба захиргааны эрх бүхий байгууллагууд шийдвэр гаргахдаа өрсөлдөөний эрх зүйн орчныг судлах шаардлагатай байна.

Энэхүү шийдвэр нь зөвхөн нэхэмжлэгчээс гадна энэ төрлийн худалдаа эрхэлдэг гуравдаг этгээдүүдийн эрх ашгийг хамгаалсан гэж үзэж байна. Уг тохиолдол нь зөвхөн электрон тамхийг худалдан борлуулахыг хориглосон гэхээсээ илүүтэй аливаа нэг нэр төрлийн бүтээгдэхүүнийг тухайн газар нутаг дээр шууд худалдан борлуулахыг хориглож байгаа үйлдэл нь өрсөлдөөнд харш байгаа юм. Жижиг дунд бизнес эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахыг тулд олон төрлийн шалгуурыг давж өөрийн хөрөнгөө бүрдүүлэхийн тулд хөрөнгө оруулалтын зориулалттай зээл авч худалдан борлуулах бараа бүтээгдэхүүнээ оруулж ирдэг. Ийнхүү процессын хувьд олон шат дамжлагатайгаар бизнес эрхлэгч үйл ажиллагаагаа эрхлэх шатан дээр төрийн захиргааны байгууллагаас хориглосон хязгаарласан шийдвэр гаргах нь өрсөлдөөнд харш байгаа юм.

Дүн шинжилгээ болон кейс анализын дүгнэлт


Нөлөөллийн шинжилгээ болон кейс анализын хүрээнд захиргааны байгууллагаас шийдвэр гаргахдаа зарим тохиолдолд эдийн засагт сөрөг үр дагавартай өрсөлдөөнийг хязгаарласан шийдвэр гаргадаг болох нь илүү тодорхой болж байна. Бизнес эрхлэгчдийн хувьд эдгээр шийдвэрүүд нь маш олон сөрөг үр дагавартай. Жишээлбэл тухайн бүс нутагт иргэн А электрон тамхи түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулдаг жижиг лангуу ажиллуулахаар арилжааны банкнаас зээл авч үйл ажиллагаагаа эхлээд удаагүй байхад засаг дарга хориглосон захирамж гаргавал бизнес эрхлэгчийн алдагдлыг хэн хариуцах вэ гэдэг асуудал яригдах юм. Иймд Захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа эдийн засаг болон өрсөлдөөнийг асуудлыг үргэлж чухалчлан авч үзэж байх хэрэгтэй.

2.2 Захиргааны байгууллагын шийдвэр жижиг дунд бизнес эрхлэгчдийн зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлаж байгаа эсэхийг тогтоох нь

Судалгааны ажлын явцад захиргааны байгууллага зарим тохиолдолд өрсөлдөөнийг хязгаарладаг шийдвэр гаргадаг нь тодорхой болсон билээ. Тэгвэл бодит

амьдрал дээр өдөр тутамдаа захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг эсэхийг илүү тодорхой болгохын тулд жижиглэн худалдаа эрхлэгчдээс буюу бизнес эрхлэгчдээс судалгааны асуулгын аргыг ашиглан тандалт судалгаа хийж дүгнэлт боловсрууллаа. Ингэхдээ аж ахуй нэгжийн төвлөрлийн статистикийг судлан үндсэн хоёр дүүргийг сонгосон болно. Улаанбаатар хотын хэмжээнд хамгийн их хүн амтай үндсэн хоёр дүүрэг нь Баянзүрх болон Сонгинохайрхан дүүргүүд юм. Мөн Баянзүрх дүүрэг нь хамгийн их ААН төвлөрсөн бүс гэдгийг дараах харьцуулсан судалгаанаас харж болно.

Зураг 2.1 ААН-үүдийн үйл ажиллагаа явуулж буй байриил



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ийнхүү судалгааг Захиргааны байгууллагаас өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд гаргаж буй аливаа хэлбэрийн шийдвэрүүд нь бодит байдалд хэрэгжихдээ өрсөлдөөнийг хязгаарласан эсэхийг шалгахын тулд УБ хотын Баянзүрх, Сонгино хайрхан дүүргийг хамруулан 36 жижиглэн худалдаа эрхлэгчдийн хүрээнд /6, 8 нэрийн хүнсний дэлгүүр, бэлэн хувцас, барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгчидийг хамруулсан/ 5 асуулга

бүхий судалгааг авч дүгнэлт боловсруулсан болно. Судалгааны асуулгууд нь тийм болон үгүй гэсэн сонголтод хариултаас бүрдсэн. Судалгааны үр дүнг үнэн зөв гаргахын тулд асуултуудыг дэлгэрэнгүй, ойлгомжтой энгийн үг хэллэг ашиглан боловсрол үл харгалзан ойлгох байдлаар бичсэн болно.

Судалгааны арга зүй

Нэгдүгээр бүлгийн судалгааны үр дүнд ААЭ-дийг салбар бүрээр нь ангилсан тоон мэдээллэлд үндэслэн худалдааны салбарт түүвэр судалгааг хийхээр сонгож авлаа.

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах тухай аман болон бичгийн хэлбэрээр өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд, нутаг дэвсгэртээ гаргаж буй шийдвэр нь бодит байдалд хэрэгжихдээ өрсөлдөөнийг хязгаарласан эсэхийг шалгахын тулд УБ хотын Баянзүрх, Сонгино хайрхан дүүргийн нийт 36 жижиглэн худалдаа эрхлэгчдийн хүрээнд /6, 8 нэрийн хүнсний дэлгүүр, бэлэн хувцас, барааны дэлгүүрийн үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулсан/ 5 асуулга бүхий судалгааг авч дүгнэлт боловсруулсан болно.

Судалгааны үр дүн

Хүснэгт 2.2 Тандалт судалгаа

№	Асуулт	Тийм	Үгүй
1	Таныг бизнесийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байхад аливаа төрлийн захиргааны байгууллагаас хориглосон, хязгаарласан, зогсоосон арга хэмжээ авч байсан эсэх.	44.4 % 16	55.6% 20
2	Худалдан борлуулж буй бүтээгдэхүүний үнэ тарифтай холбоотойгоор хязгаарлалтыг захиргааны байгууллагаас хийж байсан эсэх. /Жишээлбэл А бүтээгдэхүүнийг 1000 төгрөгөөс илүү зарж болохгүй гэх зэрэг/	38.9% 14	61.1% 22
3	Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байх явцад захиргааны байгууллагаас хяналт шалгалт хийж тухайн борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифыг буулгах агуулга бүхий удирдамж, чиглэлийг аман болон бичгэн байдлаар өгч байсан эсэх	52.8% 19	47.2% 17
4	Таныг бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулж байх явцад аливаа нутаг дэвсгэрийн хязгаарлалт захиргааны байгууллагаас хийж байсан эсэх. /Жишээлбэл таныг үйл ажиллагаа эрхэлж	47.2% 17	52.8% 19

	байгаагаасаа өөр газар эрхэлж болохгүй гэх мэтээр хязгаарлалт хийх үйлдлийг ойлгоно/		
5	Аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгохын тулд таны борлуулалт, үйл ажиллагаанд захиргааны байгууллагаас аливаа төрлийн хориглолт, хязгаарлалт хийж байсан эсэх.	38.9% 14	61.1% 22

Судалгааны дүгнэлт:

Нийт 36 жижиглэн худалдаа эрхлэгчээс авсан судалгаа нь Захиргааны байгууллага нь практикт үйл ажиллагаагаа явуулж, эрх хэмжээнийхээ хүрээнд ажиллахдаа тэдний хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц, өрсөлдөөнийг хязгаарлах үйлдлийг судалсан болно. Судалгааны үр дүнд Захиргааны байгууллага тухайн бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй жижиглэн худалдаа эрхлэгчид болох бизнес эрхлэгчдэд хяналт, шалгалт хийхдээ зах зээлийн өрсөлдөөнийг хязгаарлах агуулга бүхий шийдвэрийг аливаа төрлөөр гаргадаг болох нь судалгааны үр дүнд илүү нотлогдож байна. Ингэхдээ Захиргааны байгууллагаас бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байх явцад захиргааны байгууллагаас хяналт шалгалт хийж тухайн борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифыг буулгах агуулга бүхий удирдамж, чиглэлийг аман болон бичгэн байдлаар өгч байсан тохиолдол хамгийн их буюу нийт оролцогчдын 52.8 хувь нь тийм гэсэн хариултыг сонгожээ. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 2 бизнес эрхлэгч тутмын нэг нь тухайн бүс нутагт холбогдох захиргааны байгууллагын ажилтнуудаас аливаа хэлбэрээр үнэ тарифыг буулгахтай холбоотой чиглэл зааврыг авч байсан байна. Энэ нь Захиргааны байгууллага МУ-ын Өрсөлдөөний хуулийн 13-р зүйл болох Төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлахыг хориглох тухай зүйлийг үйл ажиллагаандаа хангалттай хэмжээнд мөрддөггүй гэж үзэх үндэслэл бүхий эргэлзээг төрүүлж байгаа юм.

Бүлгийн дүгнэлт:

Захиргааны байгууллага нь өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэр гаргах төрийн гүйцэтгэх эрх мэдлийг шууд болон шууд бусаар хэрэгжүүлэгч байгууллагууд юм. Эдгээр байгууллагууд нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ зах зээлийн буюу чөлөөт эдийн засгийн гүнзгий мэдлэггүйн улмаас ААН-үүдийн үйл ажиллагааг хориглосон

хязгаарласан буюу сөрөг нөлөөлөл бүхий актыг үйлдэх эсхүл хөндлөн түвшинд үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүдээс онцгойлон нэгт нь зөвшөөрсөн түүнд ашигтай шийдвэр гаргах замаар өрсөлдөөнийг хязгаарлах үйлдэл хийдэг байна. Захиргааны байгууллагаас гаргаж буй энэхүү өрсөлдөөнийг хязгаарлах үйлдэл нь нийтийн эрх зүйн маш олон хууль тогтоомжийн хүрээнд явагддаг учраас зарим тохиолдолд хуулиар зөвшөөрсний дагуу сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гаргаж байгааг нэхэмжлэг тал болох ААН хангалттай сайн хууль эрх зүйн мэдлэггүйн улмаас шүүхэд хандаж цаг хугацаа болон эдийн засгийн хувьд хохирох тохиолдлууд гарч байна. Тэгвэл өрсөлдөөний тухай хуулиар захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарлах үйлдэл гаргахыг хэрхэн хориглодог, тэдгээрийн үр дүн зэргийг дараагийн бүлэгт судлах болно.

III. БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Өмнөх бүлэгт дурдсанчлан манай улсын шударга өрсөлдөөнийг хангахын тулд ажилладаг хамгийн том байгууллага бол ШӨХТГ (Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар) юм. Уг байгууллага нь МУ-ын зах зээлд чөлөөт өрсөлдөөний таатай орчин бүрдүүлж, шударга нээлттэй зах зээлийг бий болгох, хэрэглэгчийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилготой. Тэгвэл энэхүү бүлгээр бусад улс оронд ямар төрийн захиргааны байгууллагууд шударга өрсөлдөөнийг хангах зорилготой ажилладаг тухай авч үзэх болно.

3.1 Шударга өрсөлдөөний төлөө захиргааны байгууллага

Өмнөх бүлэгт дурдсанчлан манай улсын шударга өрсөлдөөнийг хангахын тулд ажилладаг хамгийн том байгууллага бол ШӨХТГ (Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн төлөө газар) юм. Уг байгууллага нь МУ-ын зах зээлд чөлөөт өрсөлдөөний таатай орчин бүрдүүлж, шударга нээлттэй зах зээлийг бий болгох, хэрэглэгчийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх зорилготой. Тэгвэл энэхүү бүлгээр бусад улс оронд ямар төрийн захиргааны байгууллагууд шударга өрсөлдөөнийг хангах зорилготой ажилладаг тухай авч үзэх болно.

Амеркийн Нэгдсэн Улс

- Холбооны Худалдааны Комисс (Federal Trade Commission):

Уг байгууллага нь АНУ-ын Монополийн эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй бие даасан холбооны агентлаг юм. Үндсэн үйл ажиллагаа нь монополийг хянах, үнэ тогтоох, шударга бус өрсөлдөөн гэх мэт өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хянах тэдгээрээс урьдчилан сэргийлэх зорилготой ба энэ төрлийн зөрчлүүдэд хяналт шалгалт хийж арга хэмжээ авдаг хэрэглэгчдийн төлөөх байгууллага юм.

- Хууль зүйн яамны дэргэдэх Монополийн эсрэг хэлтэс (Department of Justice Antitrust Division)

Монополь, Шударга бус өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа явуулдаг томоохон байгууллагуудын нэг бол хууль зүйн яамны дэргэдэх Монополийн эсрэг хэлтэс юм. Уг хэлтэс нь Монополийн эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилготойгоор ажилладаг. Мөн өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх эрхтэй ба ингэхдээ Холбооны худалдааны Комисстой хамтран ажилладаг.

- Мужийн хэмжээний өрсөлдөөний байгууллагууд (State-Level Competition Authorities):

АНУ нь газар нутгийн онцлогоос шалтгаалан зарим тохиолдолд дээрх хоёр байгууллага бүрэн дүүрэн хүрч ажиллаж чаддаггүйтэй холбоотойгоор муж бүрд шударга өрсөлдөөнийг хангах зорилготой ажилладаг мужийн өрсөлдөөний байгууллагууд байдаг байна. Уг байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь монополийн эсрэг хууль тогтоомжийг өөрийн бүс нутагт мөрдөх, хянан шалгах, аливаа хэлбэрээр өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хянан шалгах зэрэг үндсэн үйл ажиллагааг явуулдаг байна.

Европын холбооны улсууд:

- Европын комисс (European Commission):

Европын холбооны хэмжээнд өрсөлдөөний хууль тогтоомжийг хэрэгжүүлдэг томоохон байгууллага юм. Уг байгууллагын үндсэн үйл ажиллагаа нь Европын зах зээлд нөлөөлж буй томоохон ААН-үүдийг өрсөлдөөнд харшлах үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг хянан шалгах гол чиг үүргийг хэрэгжүүлдэг. Уг байгууллагын өрсөлдөөний бодлого нь зах зуулд шударга өрсөлдөөнийг хангах, зах зээлийн давуу байдал ноёрхлоо урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, өрсөлдөөнд нөлөөлж болзошгүй аливаа нэгдэл картелийн шинж чанартай хэлцэл зэргийг хянан шалгах юм.

- Өрсөлдөөний үндэсний байгууллагууд (National Competition Authorities):

Европын холбооны гишүүн улс бүр Европын комисстой хамтран ажилладаг өөрсдийн орны өрсөлдөөний байгууллагатай байдаг. Жишээлбэл Их британид Өрсөлдөөн, зах зээлийн газар, Германы Шударга өрсөлдөөний төлөөх газар /Bundeskartellamt/ зэрэг нь өөрсдийн улс орны хэмжээнд шударга өрсөлдөөний төлөө ажилладаг бөгөөд хил дамнасан өрсөлдөөний асуудлаар Европын комисстой хамтран ажилладаг.

- Шударга бусаар нэгдэхийн эсрэг хяналт (Merger control):

Европын холбоонд хөндлөн түвшинд ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг хууль бусаар нэгдэн үгсэн хуйвалдаж өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахын эсрэг системтэй. Европын Комиссоос өөрсдийн тодорхойлсон тодорхой шалгуурыг хангасан томоохон бизнесүүдийн нэгдэн нийлэх, худалдан авалт хийх зэрэг үйл ажиллагаанд нь хяналт тавьдаг. Ийнхүү улс орон бүр байршлын бүс нутгаасаа

шалтгаалан өөр өөрийн гэсэн шударга өрсөлдөөний төлөөх үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай байна.

3.2 Төрийн захиргааны байгууллагаас зах зээлийн өрсөлдөөнд оролцох оролцоо

Захиргааны байгууллагаас өрсөлдөөнд оролцох үйлдлийг судлахдаа татаас буюу дэмжлэгийн асуудлыг зайлшгүй хөндөх шаардлагатай. Төрийн зүгээс зарим салбар эсхүл ААН-д дэмжлэг үзүүлэх зорилгоор санхүүгийн туслалцаа үзүүлэх ойлголтыг татаас хэмээн нэрлэдэг. Төрийн зүгээс олгох санхүүгийн дэмжлэг нь ДХБ-ын 1994 оны ГАТТ (General Agreement on Tariffs and Trade) хэлэлцээрт тусгалаа олсноор дэлхий нийтийг хамрах болсон ухагдахуун юм. Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 6 болон 16-р зүйлд тулгуурлан шинэчилсэн Субвенцийн (Орос хэлэнд татаас, санхүүгийн дэмжлэг гэсэн утгатай үг болно) тухай кодекс нь төрөөс санхүүгийн туслалцаа олгоход мөрдөх журмыг “гэрлэн дохионы зарчмаар” зохицуулсан байдаг(Б. Буянхишиг, n.d.).

Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр(1947)-ийн гол зорилго нь худалдаа, эдийн засгийн салбарын харилцаа нь амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ажлын байраар бүрэн хангах, бодит орлого болон эрэлт хэрэгцээний хэмжээг хурдацтай өсгөх, дэлхийн нөөц баялгийг бүрэн ашиглах боломжийг бүрдүүлэх барааны үйлдвэрлэл, худалдааг өргөжүүлэх чиглэлээр хөгжих ёстой гэдгийг оролцогч талууд хүлээн зөвшөөрч, тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчлэн олон улсын худалдаан дахь алагчлах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх замаар дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах(хамтын нөхөрлөл et al., n.d.) юм. Уг хэлэлцээрийн 6 болон 16 дугаар зүйлийг дэлгэрүүлэн авч тайлбарлая:

- 6 дугаар зүйл – Демпингийн эсрэг болон татаасын хариу татвар

Демпинг гэдэг нь аливаа бараа бүтээгдэхүүнийг бодит зардлаас нь доогуур үнээр борлуулах буюу өөрийн өртгөөс нь хямд зарахыг ойлгоно. Уг зүйл заалтад олон улсад ямар үйлдлийг демпинг гэж үзэхийг нарийвчлан тусгасан байна. Үүнд:

- (a) худалдааны хэвийн нөхцөлд экспортлогч орны өөрийн хэрэглээнд ашиглагддаг ижил барааны харьцуулах үнээс доогуур; эсхүл
- (b) дотоодын харьцуулах ийм үнэ байхгүй тохиолдолд дараахь хоёрын аль нэгнээс доогуур байх нөхцөлд:

- (i) худалдааны хэвийн нөхцөлд аливаа гуравдагч оронд экспортлоход зориулагдсан ижил барааны харьцуулсан хамгийн дээд үнээс; эсхүл
- (ii) гарал үүслийн орон дахь барааны үйлдвэрлэлийн өртөг дээр борлуулалтын зардал болон ашгийг боломжийн хэмжээгээр нэмсэн дүнгээс.

Дээрх үйлдлүүдийг гаргасан тохиолдолд хариуцлагын хувьд гарсан демпингийг арилгах зорилгоор зөрүүтэй үнийн дүнгийн хэмжээгээр тухайн бараа бүтээгдэхүүнд татвар ноогдуулж болдог ажээ. Уг ногдуулж буй татварыг демпингийн эсрэг татвар гэж нэрлэдэг байна. Харин татаасын хариу татвар гэдэг нь аливаа барааны үйлдвэрлэл, боловсруулалт, эсхүл экспортод шууд буюу шууд бусаар олгож буй аливаа үнийн урамшил, эсхүл татаасыг тэгшитгэн саармагжуулах зорилгоор ногдуулж буй тусгай татварыг хэлнэ(хамтын нөхөрлөл et al., n.d.).

- 16 дугаар зүйл Татаас:

Энэхүү зүйл заалтаар татаасын ерөнхий зарчим болоод экспортын талаар нарийвчлан тусгасан байна.

Татаасын ерөнхий зарчим гэдэг нь оролцогч аль нэг тал экспортыг нэмэгдүүлж, импортыг бууруулах зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлэн татаасын үйл ажиллагаа зохион байгуулж байгаа тохиолдолд тухайн татаасын зайлшгүй шаардлагатайг нотлох үүрэг хүлээдэг байна. Мөн тухайн татаасыг ашигласнаар нөгөө талын улсад ноцтой хохирол учруулах, учруулж болзошгүй нөхцөл байдалд хүрвэл хэлэлцэн тохирогч талуудтай хамтран татаасыг хязгаарлах боломжийн тухай хэлэлцдэг байна. Экспортын татаасын нэмэлт заалтуудад хэлэлцэн тохирогч талууд анхдагч бүтээгдэхүүнийг экспортлоход татаас олгохоос зайлхийх буюу шаардлагатай тохиолдолдлоос бусад үед хориглодог байна.


Манай улсад төрөөс санхүүгийн дэмжлэг болгон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Зээлийн батлан даалтын сан, Сум хөгжүүлэх сан гэх мэт хөнгөлөлттэй зээл олгож татаасын арга хэмжээг авдаг байна.

3.2.1 Татаас буюу дэмжлэг /Subsides/

Татаас гэдэг нь засгийн газар, эсхүл засгийн газрын аливаа байгууллага буюу Захиргааны байгууллагуудын зүгээс аливаа нутаг дэвсгэрийн хүрээнд үзүүлж байгаа

санхүүгийн туслалцааг ойлгоно. Өөрөөр хэлбэл татаас нь Засгийн газраас мөнгөн хөрөнгийг шууд шилжүүлэх тухайн зах зээлийн өрсөлдөөнд шууд хэлбэрээр оролцож тусламж үзүүлэхийг ойлгоно.

Зураг 3.1 Татаасын төрөл



Эх сурвалж: World trade organization, 2022

Дээрх зурагт тайлбарласнаар татаасыг засгийн газар эсвэл аливаа төрийн байгууламжийн санхүүгийн тусламжтайгаар хийдэг ба хэлбэрийн хувьд шууд болон шууд бус хандив, тэтгэмж зэргээр хүлээн авагчид шилждэг байна. Хүлээн авагч гэдэгт ААН, Үйлдвэрлэл эсвэл газарзүйн тодорхой бүс нутгийн хамруулан ойлгож болно. Мөн уг татаас хэмээх ойлголтод хориотой татаас багтдаг ба энэ нь дотоодын үйлдвэрлэлд тусламж үзүүлэхгүй атлаа импортыг дэмжих импортын татварын хөнгөлөлт эдлүүлэх гэх мэт үйл ажиллагааг ойлгоно.


Татаас олгож буй эрх бүхий байгууллага болон татаас авч буй байгууллагын дагаж мөрдөж буй хууль тогтоомж нь татаас авах боломжийг зөвхөн тодорхой үйлдвэрээр нарийвчлан хязгаарлаж байгаа бол уг төрлийн татаас нь тусгайлсан шинжтэй татаасд хамаарна. Олон улсад дараах төрлийн татаасууд байдаг байна (*Third Technical Workshop on Afghanistan's Accession to the World Trade Agreement - WTO Agreement on Subsidies and Countervailing Measures (ASCM) by Mr. Rajesh Aggarwal, n.d.*).

- Шууд татаас: Энэ төрлийн татаас нь төрөөс ААЭ-д мөнгөөр туслахыг ойлгоно.
- Татварын татаас: Засгийн газар тодорхой үйлдвэр, үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэхийг ойлгоно. Манай улсын хувьд энэ төрлийн

татаас их байдаг. Дэлхий даяар тархсан хамгийн түгээмэл жишээ бол Коронавирус цар тахлын үед аан-үүдийг татвараас хөнгөлж байсан тохиолдол юм

- Үнийн татаас: Үнийн татаас нь хэрэглэгчдэд зориулсан бараа, үйлчилгээний өртгийг бууруулах төрийн оролцоог хамардаг. Хүнс, эрчим хүч гэх мэт нийтээр хэрэглэдэг зайлшгүй үнийг нь буулгах шаардлагатай бараа бүтээгдэхүүний үнийг бууруулахын тулд үйлдвэрлэгчдэд санхүүгийн тусламж, татаас зэргийг олгохыг ойлгож болно.
- Экспортын татаас: Засгийн газар зарим тохиолдолд дотоодын үйлдвэрлэлээ дэмжихийн тулд экспортын нөхцөлийг сайжруулах татварыг хөнгөлөх гэх мэт гадны зах зээлд бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулахад тохирсон таатай нөхцөл байдлыг бий болгодог.
- Үйлдвэрлэлийн татаас: Үйлдвэрлэлийн татаас нь үйлдвэрлэлийн зардлыг бууруулах замаар тодорхой үйлдвэр, салбарыг дэмжих зорилготой. Үүнийг шууд төлбөр буцалтгүй тусламж эсвэл эрчим хүч, түүхий эд гэх мэт оролцоог ойлгох боломжтой.

Зураг 3.2 Засгийн газрын татаасын ангилал



Эх сурвалж: World Trade Organization

Дээрх зургаас харвал засгийн газрын татаас нь үндсэн гурав ангилагддаг байна. Үүнд:

- Хориотой татаас,
- Үйл ажиллагаа явуулах боломжтой татаас,
- Үйлдэлгүй татаас

Ийнхүү татаас хийхдээ дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орны эрх ашгийн хөндөхгүй байх шаардлагатай бөгөөд экспортын татаас болон дотоодын хэрэглээнд хамаарах татаасууд хориотой байдаг байна.

3.2.2 Хариу арга хэмжээний тухай /Countervailing measurements/

Экспортлогч улсын үйлдвэрлэгч эсвэл экспортлогчдод олгосон татаасыг нөхөх зорилгоор импортлогч орны авч буй арга хэмжээг ойлгоно. Жишээлбэл, хэрэв аль нэг А улс азрын тос, байгалийн хийн пүүсүүдэд хайгуул, олборлолтын томоохон татаас олгодог бол өөр нэгэн Б улс дотоодын газрын тос, байгалийн хийн олборлогчдоо гадаадын өрсөлдөгчидтэй ижил түвшинд байлгахын тулд А улсаас газрын тос, байгалийн хийд нөхөн татвар ногдуулж болно. Дараах үйл ажиллагаанууд хариу арга хэмжээнд хамаарна.

Хянан шалгах ажиллагаа:

Аль нэг улс өөр улс аж үйлдвэрээ шударга бусаар татаас өгч байна хэмээн сэжиглэж байгаа тохиолдолд нотлох баримтаа цуглуулж, татаас нь дотоодын үйлдвэрлэлдээ үзүүлэх нөлөөг үнэлэх зорилгоор мөрдөн байцаалтын ажиллагааг эхлүүлж болно.

Хохирлыг тогтоох:

Хөнгөлөлттэй импорт нь дотоодын үйлдвэрлэлд материаллаг хохирол учруулсан эсвэл хохирол учруулах аюул учруулсан тохиолдолд албан ёсны байгууллага үнэлэн тогтоодог. Энэхүү үнэлгээнд дотоодын аж үйлдвэрийн зах зээлд эзлэх хувь, ажил эрхлэлт, үйлдвэрлэлийн хүчин чадал, санхүүгийн үзүүлэлт зэрэг хүчин зүйлсийг авч үздэг.

Нөхөн төлбөр ногдуулах:

Мөрдөн байцаах байгууллага татаас нь материаллаг хохирол учруулж байна гэж дүгнэвэл татаастай импортод нөхөн татвар ногдуулах боломжтой. Эдгээр татварууд нь татаасын үр нөлөөг нөхөх, дотоодын үйлдвэрлэгчдийн өрсөлдөөнийг тэгшитгэх зорилготой нэмэлт тариф юм.

ДХБ-ын дүрмийг дагаж мөрдөх:

Сөрөг арга хэмжээ нь олон улсын худалдааны дүрэм, ялангуяа Дэлхийн худалдааны байгууллагаас тогтоосон дүрэмд нийцсэн байх ёстой. ДХБ-ын дүрмүүд нь мөрдөн

байцаалтын үйл явц, хохирлыг тодорхойлох, нөхөн төлбөрийн хэмжээг тооцох зааварчилгааг өгдөг.

Бүлгийн дүгнэлт

Энэхүү бүлэгт бусад улс орны шударга өрсөлдөөний төлөөх захиргааны байгууллагуудыг судалсан болно. Ихэнх орнууд газар нутаг, хүн ам, ААН-ийн тоо зэргээсээ шалтгаалан хэд хэдэн шударга өрсөлдөөний төлөөх шаталсан захиргааны байгууллагатай байдаг бол манай улсын хувьд үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэгч нэг байгууллага байдаг байна. Мөн олон улсын худалдааны эрх зүй дэх татаас болон хариу арга хэмжээний тухай авч үзсэн бөгөөд тухайн улс дотоодын үйлдвэрлэл, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд ААН-д, бизнес эрхлэгчид, зарим бүс нутагт мөнгөн тусламж үзүүлэхийг ойлгодог байна.

Манай улсын хувьд татаасын эрх зүйн орчныг өөрсдийн хууль эрх зүйн орчинд нарийвчлан тусгах шаардлагатай хэмээн дүгнэж байна. Учир нь манай улс саяхан өргөн хэрэглээний голлох бүтээгдэхүүн болох гурилын импортын татварыг буулгаж хямд зарах талаар хэд хэдэн шийдвэр гарсан. Гэвч олон улсын худалдааны байгууллагын татаасын тухай судлахад энэхүү шийдвэр нь хориг татаасд орохуйц шийдвэр байгаа юм. Иймд дотоодын үйлдвэрлэл, ААН-үүдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд татаасын нарийвчилсан зохицуулалт шаардлагатай.

ДУГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлаар өрсөлдөөний эрх зүйг нийтийн эрх зүйн хүрээнд нарийвчлан судаллаа. Ингэхдээ захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах шийдвэр гаргадаг эсэхийг судлахын тулд нийт гурван төрлийн үндсэн судалгааг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Нөлөөллийн шинжилгээ
- Кейс анализ
- Тандалт судалгаа

Дээрх судалгаануудын үр дүнд захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ өрсөлдөөний эрх зүйд харш буюу өрсөлдөөнд оролцож түүнийг хязгаарлахад чиглэсэн шийдвэр зарим тохиолдолд гаргадаг болох нь тодорхойлогдож байна. Онолын хувьд төрийн захиргааны байгууллага эдийн засаг, өрсөлдөөнд огт оролцохгүй байх нь сөрөг нөлөөтэйг судалгааны хэсгээрээ бататгасан болно. Зах зээлийн чөлөөт зарчим алдагдахуйц шударга бус байдал бий болсон тохиолдол буюу ААН-үүд шударгаар өрсөлдөхгүй байгаа үед төрийн зайлшгүй зохицуулалт шаардлагатай. Харин төрийн захиргааны байгууллагын хэт их оролцоо нь чөлөөт эдийн засгийн үндсэн зарчимтай зөрчилдөж нийгэм, эдийн засгийн хувьд ихээхэн гарз хохирол учруулах боломжтой. Гэвч манай улсын Захиргааны байгууллагын зах зээлийн өрсөлдөөнд оролцох оролцоо ихсэж байгаа ба үндсэн шалтгаанууд нь эрх бүхий албан тушаалтнууд гаргаж буй захиргааны актадаа нөлөөллийн шинжилгээ хийдэггүй, хууль эрх зүйн орчны мэдлэг бага, зах зээлийн зарчим, чөлөөт өрсөлдөөний тухай мэдлэггүй зэргээс болж байгаа нь судалгаагаар илүү батлагдсан болно.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Төрийн захиргааны байгууллагаас аливаа төрлийн захиргааны үйл ажиллагаа явуулахдаа нөлөөллийн шинжилгээг зайлшгүй олон нийтэд нээлттэй хийж, эрх ашиг нь хөндөгдөх иргэдэд зайлшгүй мэдэгдэх эрх зүйн зохицуулалт хийх.
2. Өрсөлдөөний тухай хууль тогтоомжийн биелэлтийг нэмэгдүүлэхийн тулд хяналтыг сайжруулах бодлогын арга замыг нарийвчлан тодорхойлох.
3. Захиргааны байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйлдэлтэй холбоотой илүү өргөн хүрээний тандалт судалгаа авч боловсруулалт, дүн шинжилгээ хийх.
4. Захиргааны байгууллагуудад өрсөлдөөнийг хязгаарлахтай үйлдэлтэй холбоотой зөвлөмж хүргэх.
5. Захиргааны байгууллагууд болон эрх бүхий албан тушаалтнуудад эрх хэмжээнийхээ хүрээнд ажиллахдаа эдийн засгийн зарчим болон өрсөлдөөний тухай хуулийг чанд мөрдөн ажиллах эрх зүйн зохицуулалт хийх.

НОМ ЗҮЙ

Монгол хэл дээрх:

1. Баярмаа. Н, *Өрсөлдөөний эрх зүй ба гэрээ.*
2. Буянхишиг. Б, (n.d.). *Төрөөс санхүүгийн дэмжлэг олгох ажиллагааг хянах механизм, эрх зүйн хамгаалалт.*
3. Банзрагч. Г,(2013). *Эдийн засгийн захиргааны эрх зүй.*
4. Банзрагч. Г, (2016). *Эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтын нийтийн эрх зүйн үндэс, анхаарах асуудлууд.*
5. Дарханболд. О, *Эрх зүйн салбарт эдийн засгийн ойлголтыг хэрэглэх шаардлага*
6. ЖАЙКА, Ш.-ын судлаачид. (2017). *“Монгол дах шударга өрсөлдөөний орчныг бэхжүүлэх нь” техникийн хамтын ажиллагааны төсөл, тайлан, гарын авлага*
7. Мөнх-Эрдэнэ.Т, (n.d.). *Өрсөлдөөний эрх зүй: Хувийн ба нийтийн эрх зүйн зэрэгцэл*
8. Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ. (n.d.). *Өрсөлдөөний хууль ба бодлого-хэрэгжүүлэгчдэд зориулсан гарын авлага.*
9. Нэгдсэн үндэсний байгууллагын худалдаа хөгжлийн бага хурал ба ШӨХТГ. (n.d.). *Өрсөлдөөний хууль ба бодлого-хэрэгжүүлэгчдэд зориулсан гарын авлага.*
10. Норовсүрэн. Х, *Цар тахлын үеийн өрсөлдөөний эрх зүйд аж ахуйн нэгжийн ашиг сонирхолыг хамгаалах асуудал*
11. Одгэрэл. П, (n.d.). *Захиргааны эрх зүйн ерөнхий анги.*
12. Отгонбаяр. Л, (2023). *Монгол улсын өрсөлдөөний эрх зүй дэх картелийн тодорхойлолт: Онол, Үзэл баримтлал, Шүүмж. Хууль Дээдлэх Ёс.*
13. Отгонбаяр. Л, (эмхэтгэсэн). (2023). *Монгол улсын Өрсөлдөөний эрх зүйн эх сурвалжид холбогдох баримт бичиг (1993-2022).*
14. Отгонбаяр. Л, *Шерманы хуулийн эх сурвалж: түүхэн тойм, өрсөлдөөний эрх зүйг хөгжүүлэхэд түүний ач холбогдол*
15. Энхжаргал. Т, *Засгийн газрын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохицуулалтын зарим асуудал*
16. Энхтайван. Л, *Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ*
17. ШАХБ-ын хамтын нөхөрлөл, *1947 оны тариф, худалдааны ерөнхий хэлэлцээр.*
18. Паркин. (n.d.). *Макро-Экономикс.*
19. Цогт. Ц, *Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ: хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт*

Гадаад хэл дээрх:

20. Analysis of Subsidy Arrangements in Indonesia in View of the SCM Agreement
(Agreement on Subsidies and Countervailing Measures)
21. *Competition Law and Policy* By Barry J. Rodger, Angus Macculloch
22. *Competition Policy: Theory and Practice* By Massimo Motta
23. *Third Technical Workshop on Afghanistan's Accession to the World Trade Agreement - WTO Agreement on Subsidies and Countervailing Measures (ASCM)* by Mr. Rajesh Aggarwal. (n.d.).
24. *European competition law and Economics*. By Roger van den Bergh, Peter D. Camesasca
25. *The International Dimension of EU Competition Law and Policy* By Anestis S. Papadopoulos
26. *Law and Economics of Contingent Protection in International Trade* by Kyle W. Bagwell, George A. Bermann,
27. *Free Zones and the World Trade Organization Agreement on Subsidies and Countervailing Measures* *Global Trade & Cust. J.* 217 (2007)
28. Why can't countervailing duties deter export subsidization? Larry D. Qiu
29. Subsidies, Countervailing Duties and Antidumping After the Tokyo Round Cornell Int'l L.J. 257 (1980)
30. In the shadow of subsidies: WTO'S regulatory framework

Хууль тогтоомж:

31. Монгол улсын үндсэн хууль, 1992 он
32. Өрсөлдөөний тухай хууль, 2010 он
33. Захиргааны ерөнхий хууль, 2015 он
34. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Тандалт судалгааны асуулга:

1. Захиргааны байгууллагаас таны бизнест хориглосон, хязгаарласан, зогсоосон арга хэмжээг ямар нэгэн байдлаар хийж байсан эсэх.

А. Тийм

Б. Үгүй

2. Таны худалдан борлуулж буй бүтээгдэхүүний үнэ тарифтай холбоотой хязгаарлалтыг захиргааны байгууллагаас хийж байсан эсэх. /Жишээлбэл А бүтээгдэхүүнийг 1000 төгрөгөөс илүү зарж болохгүй гэх зэрэг/

А. Байсан

Б. Байгаагүй

3. Таныг бизнесээ эрхэлж байхад захиргааны байгууллагаас борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тарифыг буулгах агуулга бүхий удирдамж, чиглэлийг аман болон бичгийн хэлбэрээр өгч байсан эсэх. \Жишээлбэл: Хорооны холбогдох ажилтан танай дэлгүүрт орж ирээд танай бараа гадуур зарж байгаагаас үнэтэй байна, үнээ буулга гэж аман байдлаар хэлэх гэх мэт\

А. Тийм

Б. Үгүй

4. Таныг бизнесээ эрхэлж байх явцад аливаа нутаг дэвсгэрийн хязгаарлалт захиргааны байгууллагаас хийж байсан эсэх. /Жишээлбэл таныг үйл ажиллагаа эрхэлж байгаагаасаа өөр газар эрхэлж болохгүй гэх мэтээр хязгаарлалт хийх үйлдлийг ойлгоно/

А. Тийм

Б. Үгүй

5. Тантай ижил төрлийн бизнес эрхлэгчид захиргааны байгууллагаас давуу байдал олгож байгаа мэт санагддаг эсэх. \Тухайн газраар үйлчлүүлэхийг иргэдэд уриалах, төрөөс дэмжлэг үзүүлэх гэх мэт\

А. Тийм

Б. Үгүй

6. Аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгохын тулд таны борлуулалт, үйл ажиллагаанд захиргааны байгууллагаас аливаа төрлийн хориглолт, хязгаарлалт хийж байсан эсэх.

А. Тийм

Б. Үгүй